

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-32

<i>1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/</i>	4-17
<i>2.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	17-32

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 07 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, Д.Цогтбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд;
Тасалсан: Н.Алтанхуяг.

Нэг.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитор Х.Баярмаа, И.Эрдэнэцэцэг, Д.Цэгмиддорж, Ч.Бумдарь, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат, Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн хэлтсийн шинжээч Ч.Цацрал, Зэвсэгт хүчний Жанжин штабын Санхүүгийн хэлтсийн дарга Б.Бүрэнтөгс, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Д.Намсрай, мөн газрын Санхүү, ар талын газрын дарга Я.Гантөмөр, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат танилцуулав.

Аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Д.Ганбат, Н.Энхболд, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Батлан хамгаалах

яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Энх-Амгалан, Б.Баттөмөр нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Васгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Золжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Д.Ганбат, Н.Энхболд, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Д.Ганбат, Н.Наранбаатар, Б.Энх-Амгалан нар үг хэлэв.

Б.Энх-Амгалан: Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
11 цаг 07 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Гишүүдийн ирц бүрдэж байна. Ажлын хэсгийг нь дуудаарай. Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Б.Энх-Амгалан ирсэн, Алтанхуяг гишүүн чөлөөтэй, Амартүвшин гишүүн гадаадад томилолттой, Анужин гишүүн ирсэн, Бат-Амгалан гишүүн гадаадад томилолттой, Баттөмөр гишүүн ирсэн, Баделхан гишүүн ирсэн, С.Батболд гишүүн чөлөөтэй, Б.Бат-Эрдэнэ гишүүн гадаадад томилолттой, Д.Ганбат гишүүн ирсэн, Дэлгэрсайхан гишүүн чөлөөтэй, Наранбаатар гишүүн ирсэн, Сэргэлэн гишүүн ирсэн, Цогтбаатар гишүүн гадаадад томилолттой, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн, Ж.Эрдэнэбат гишүүн ирсэн байна. Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 22 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2023 оны 6 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн,

хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ. 2 дахь асуудал Монгол Улс Азийн хөгжлийн банк хоорондын хоорондын аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 6 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах. Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. 1.Болдын Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд, С.Мөнгөнчимэг Сангийн дэд сайд, Ч.Тавинжил Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн удирдлагын газрын дарга, Н.Мөнгөнсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Ч.Цацрал Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн

хэлтсийн шинжээч, Үндэсний аудитын газар Д.Занданбат Монгол Улсын Ерөнхий аудитор, Ц.Наранчимэг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Д.Энхболд Аудитын 3 дугаар газрын захирал, тэргүүлэх аудитор, Я.Самбууням Аудитын 4 дүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор, Батлан хамгаалах яам, Д.Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал, Б.Оюунгэрэл Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, дэд хурандаа, Б.Бүрэнтөгс ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа, Гадаад харилцааны яам Н.Анхбаяр Гадаад. Харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ч.Ганбат Гадаад харилцааны яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, ОБЕГ, Д.Намсрай ОБЕГ-ын дэд дарга, хурандаа, Я.Гантөмөр ОБЕГ-ын Санхүү, ар талын газрын дарга, хурандаа, Цөмийн энергийн комисс Г.Манлайжав Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын алба хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна. Занданбат даргын микрофоныг өгье. 4 номерын микрофон.

Д.Занданбат: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын

үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1.Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 55 тайлан нэгтгэснээс 5 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг түүвэрт хамруулж, аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 5 байгууллагад өөрчлөлтгүй дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 909,3 тэрбум төгрөгийн сая төгрөгийн 20 зөрчил илэрснээс 3,7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 4 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 901,6 сая төгрөгийн 16 зөвлөмж өгсөн. Нийцлийн асуудлаар 21,6 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 21,6 сая төгрөгийн 2 албан шаардлага, зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 322,2 сая төгрөгийн 4 алдаа илэрснээс аудитын явцад 243,6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 78,6 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх нэг зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 8 тэрбум 400 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 8 тэрбум 400 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Үүнээс шинээр хэрэгжих 8 тэрбум 400 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээ байна. Нийт төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэлд 100 хувьтай бүрэн хэрэгжиж дууссан байна. Төсөл арга хэмжээний 22 оны санхүүжилтийн гүйцэтгэл 94,2 хувьтай байна.

Батлан хамгаалах, 2.Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 87 тайлан нэгтгэснээс 49 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 38 байгууллагыг түүвэрт хамруулж, аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 43 байгууллагад өөрчлөлтгүй, 6

байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12 тэрбум 125,2 сая төгрөгийн 49 зөрчил илэрснээс 113,6 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 9 тэрбум төгрөгийн 15 албан шаардлага хүргүүлж, 1 тэрбум 660,9 сая төгрөгийн 27 зөвлөмж өгч, 1 тэрбум 350 сая төгрөгийн 2 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн. Нийцлийн асуудлаар 421,8 сая төгрөгийн 14 зөрчил илэрснээс 1,6 сая төгрөгийн нэг төлбөрийн акт тогтоож, 142,2 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, 278 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1 их наяд юу, 1 тэрбум 829,7 сая төгрөгийн 13 алдаа илэрснээс аудитын явцад 1 тэрбум 339,7 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 490 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 23 тэрбум 614,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 тэрбум 457,4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Үүнээс шинээр хэрэгжих 23 тэрбум 614,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ байна. Нийт төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл 88,9 хувьтай, бүрэн хэрэгжиж дууссан 3, хэрэгжилт дутуу болон хэрэгжээгүй 4 төсөл, арга хэмжээ байна. Төслийн арга хэмжээний 2022 оны санхүүжилтийн гүйцэтгэл 99,5 хувьтай байна. Аудитын дүн дүгнэлтээс нэн тэргүүнд анхаарах асуудлыг тоймлон танилцуулъя.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-оос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-ээс 2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

тодорхойгүйгээс улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэх боломжгүй байна. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгааны нэг болж байна.

Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд төсвөөс санхүүжих нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлуудыг санхүүжүүлж байгаа нь төсвийн нэгдсэн бодлогын зарчмыг алдагдуулж байна. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах мөн төсөвт ачаалал үүсэж буй талаар жил бүр хийгдэж буй аудитын өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй зөрчсөн хэвээр байгаа байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Занданбат даргад баярлалаа. Энэ Монгол Улсын 2020 оны 22 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн асуудлыг бол Засгийн газар өргөн барьдаг. Тийм учраас манай Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөгчийн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит дүгнэлт хийсэн байгаа. Энэтэй холбоотойгоор асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Дараа нь би асуулт асууна. Баттөмөр гишүүн асуулт асууя.

Б.Баттөмөр: Яах вэ бид хуулийн хугацаандаа энэ төсвийнхөө гүйцэтгэлийг бол ярьж байна. Энэ төсөв бол яах вэ 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч байгаа. Санхүүгийн данс, урсгал данс, төлбөрийн

тэнцэл бүгд алдагдалтай байгаа. Дээрээс нь ямар асуудал байна гэхээр энэ өрийн асуудал байгаа юм л даа. Нийт өр бол 33,5 тэрбум доллар байгаа. Энэнээс яах вэ Засгийн газрын өр бол харьцангуй бага 8,5 орчим гэж тооцож байгаа. Тэгэхдээ одоо бол улсын өр гэхээсээ илүү төрийн өр гэдэг болчихсон тийм ээ, Монголбанк, Хөгжлийн банк, тэгээд цаашаа төрийн өмчтэй компаниудын өр гээд тэгэх юм бол нэлээн дээшилнэ, их болчихно. Тэгэхээр энэ өрийн асуудал дээрээ ер нь цаашидаа ямар менежмент хийх вэ? Яг ингээд л өнөөдөр бол өрийг өрөөр хаагаад, хугацаа нь болонгуут дахиж зээл аваад ингээд хаагаад яваад байгаа. Ер нь Монгол Улсын чадавх энэ өрөө төлөх чадавх хэзээ бий болох вэ? Нэг хүнд ноогдох өрийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлж байгаа шүү дээ 1 дүгээр асуулт энэ байна.

2 дахь асуулт бол юу гэхээр энэ юутай холбоотой асуудал байна л даа энэ нэг энэ худалдаатай холбоотой асуудал байгаа юм. Энэ худалдаанд бол ямар асуудал байна гэхээр зэрэг БНХАУ-аас хамаарах хамаарал 1992 онд 17,8 хувь байсан бол 2022 оны эцэст 93 хувь гарсан байгаа юм. Тэгээд энэ бол тоо бол юу гэхээр манай гадаад худалдаа нэг улсаас хамааралтай болно. 90 оноос хойш ОХУ-тай 30 жил хийсэн худалдаанаас 22 тэрбум долларын алдагдалтай худалдааг хийсэн байгаа. БНХАУ-тай 37 тэрбум долларын ашигтай худалдааг хийсэн байгаа. Тэгээд хамаарал бол ийм хамааралтай болчихоод байна. Гадаад худалдааны тэнцэл 21,2 тэрбум доллар болж 3,8 тэрбум долларын ашигтай болж байгаа юм, ашигтай гарч байна. Гэтэл төлбөрийн тэнцэл нь 770-аад сая долларын алдагдалтай.

Тэгээд энэ тоонуудыг яагаад яриад байна вэ гэхээр энэ Монгол Улсын аюулгүй байдал, энэ эдийн засгийн аюулгүй байдал гэдэг юмыг хаана, хэн, манай холбогдох байгууллагууд ер нь энэ дээр ямар дүгнэлт саналууд байдаг юм бэ? Аюулгүй байдлын түвшин цаашид анхаарах асуудлууд дээр ер нь ямар юм байдаг юм бэ? Үндэсний

аюулгүй байдлын зөвлөл гэж байдаг л даа. Тэгэхдээ өнөөдөр Засгийн газрын бас нэг хариуцах ёстой ажил гэж ингээж ойлгож байгаа юм. Тэгэхээр энэ дээр ер нь ямар тооцоо судалгаанууд байна вэ? Ийм асуултад хариулт авъя.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? Сангийн сайд Жавхлан хариулъя. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Батмөнх гишүүний асуултад хариулъя. Өрийн бодлого, өрийн менежмент бол маш тодорхой байгаа. Улсын Их Хурал дээр энэ асуудал 3 жил тутам яригддаг. Гадаад өрийн дунд хугацааны стратегиа бид Улсын Их Хурлаар батлуулж аваад, Засгийн газар энэний дагуу ажлаа төлөвлөөд ингээд явдаг учиртай байгаа. Одоо явж байгаа маань өнгөрсөн жилийн 5 сард батлагдсан 25 он хүртэлх дунд хугацааны өрийн удирдлагын стратегийнхаа хүрээнд явж байгаа. Гол санаа нь ерөөсөө л ийм байгаа юм. Засгийн газрын өрийг бид нар 2 хэсэг хувааж авч хардаг. Нэг нь богино хугацаатай, өндөр хүүтэй арилжааны бондын хэсэг байгаа. 2010 оноос хойш Монгол Улс олон улсын санхүүгийн зах зээл дээр бирж дээр Засгийн Монгол Улсын Засгийн газар гэдэг кодтой арилжааны бонд гаргаж эхэлсэн түүхтэй юм байгаа юм.

Нөгөөдөх нь бол урт хугацааны хөгжлийн зээлийн ийм багц байгаа. Үндсэндээ 8 тэрбум долларын маань 2,4 тэрбум доллар нь бол бондын үлдэгдэл. Бусад нь бол урт хугацаатай, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан хөгжлийн зээлүүд болон мөн 2 талтай ийм зээлүүд байдаг юм. Тэгэхээр стратеги маань яаж байгаа вэ гэхээр дахиж өндөр хүүтэй богино хугацаатай бонд гаргахгүй шүү, ийм өр тавихгүй шүү. Харин зөвхөн эдийн засгийн өндөр ач холбогдолтой, төлбөрийн тэнцэл дээр үр өгөөжтэй, Улсын Их Хурлаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд гарсан жагсаалт бүхий хөрөнгө оруулалтуудыг л зориулсан ийм хөгжлийн зээл авч болно гэсэн ийм зориулалтаар

явж байгаа, ийм төлөвлөгөөтэй явж байгаа.

Бонд сүүлийн жилүүдэд гаргасан 2 жил дараалж гаргасан *Security* бондууд бол өмнөх өндөр хүүтэй энэ цаг нь тулчихсан бондууд дээр зохицуулалт хийх зориулалттай ийм бондууд гарсан байгаа. Хөгжлийн зээлүүдийг бол бид 4, 4 жилээр Улсын Их Хурлаар дунд хугацааны төлөвлөгөөгөө батлуулж аваад, энэ хүрээндээ зориулалтын дагуу ашиглаад, зээлээ татаад ингээд явдаг учиртай. Үүгээрээ л явж байгаа. Бондын хувьд бол бид аль бол болох зохицуулалтаа хийгээд, тухайн жилд төсөв дээрээсээ бид хэдийг төлж чадахаар байна, ямар боломж байна энэ тэр хэмжээгээр төлөөд явж байгаа гэсэн үг. Энэ жил жишээ нь бид 240-өөд сая доллароор төсөв дээрээсээ шууд Гэрэгэ бондын үлдэгдлийг төлөөд явсан. Өнгөрсөн жил 150 сая доллароор Чингис бондын үлдэгдлийг шууд төсөв дээрээсээ төлөөд явсан байх жишээтэй. Ирэх жил төсвийн орон зай ямар боломж гарах нь вэ мөн төсөв дээрээсээ төлж чадах хэмжээгээрээ төлөөд ингээд явах юм байгаа юм.

Ер нь цаашидаа эдийн засаг тэлэх хэрээр, эдийн засаг хөгжих хэрээр бидний зээлдэх хэмжээ чадамж нэмэгдэнэ. Ер нь бол зээлийн дүн гэхээсээ илүү бид зээл ашиглалт дээрээ л илүү анхаарах ёстой юм байгаа юм. Тэрнээс биш улс орнуудын хөгжил энэ зээлийг аваад зөв ашигласнаараа л байдаг. Зээлээ аваад буруу зүйлд ашиглах юм бол тэгээд л ер нь дефолт л хүлээж байдаг ийм байгаа. Тийм учраас цаашидаа бид аль болох үнэтэй зээлүүдээсээ салж аваад, урт хугацааны хөгжлийн зээлүүдээ ашиглалтыг нь сайжруулаад ингээд явах л гол стратеги байгаа. Гадаад худалдаа манайх бол ер нь төлбөрийн тэнцэл маань худалдааны эдийн засагтай улс шүү дээ. Үйлдвэрлэл маш багатай. Зүгээр үндсэндээ сүүлийн 30 жил ингээж явж ирсэн байгаа юм.

Эндээс гарах бидний дунд хугацааны гол төлөвлөгөө маань ерөөсөө л Шинэ сэргэлтийн бодлого л байгаа.

Шинэ сэргэлтийн бодлого. Өөрөөр хэлбэл 30 он хүртэлх Алсын хараа 2050-ийн эхний 10 жил буюу 30 он хүртэлх эдийн засгийн хөгжлийг боомилж байгаа эдгээр шалтгаануудаасаа салъя гэдэг энэ төлөвлөгөөгөө Улсын Их Хурлаар батлуулж аваад ингээд явж байна. Төлбөрийн тэнцэл бол нэг жил нэг төсвөөр.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Гүйцээгээд хариулчихъя. Сангийн сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Тийм. Төлбөрийн тэнцэл энэ сүүлийн жилүүдэд манай Их Хурал дээр их ашигүй их сайн яригддаг болсон. Энэ рүү бас хүмүүс нэлээн анхаарал тавьдаг болсон байгаа юм. Манайх ингээд гадаад худалдааны эдийн засагтай ийм улс. Аль болох дотоодын үйлдвэрлэлээрээ л бид нар энэ төлбөрийн тэнцлийнхээ энэ гаж байдлыг гажгийг засаж явна. Тэрнээс биш нэг удаагийн, нэг жилийн хилийн нөхцөл байдлаас сайжирсан энэ нүүрсний экспорт ч гэдэг юм уу, энэ бол цаашидаа бас бид ингээд төлбөрийн тэнцлийг бүрэн эдгэчихлээ, тогтвортой байна гэж харж болохгүй. Энэ эрсдэлтэй хэвээр л байна. Тийм учраас дунд хугацаандаа төлбөрийн тэнцлээ хамгийн зөв сайжруулах бүтэц маань бол ерөөсөө л дотоодын үйлдвэрлэл байгаа.

Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээгээ бид нар хангалттай өсгөж чадаж байж энэ төлбөрийн тэнцлийн гадагшлах урсгалыг илүү богино хугацаанд сайжруулах ийм боломж байгаа гэж харж, Засгийн газар зорьж ингэж төлөвлөж ажиллаж байна. Өнгөрсөн жил, энэ жил бол яах вэ төлбөрийн тэнцэл ингээд багасаад гарч байна. Тэгэхдээ энэ бол богино хугацаанд, богино хугацаанд зөвхөн худалдааны эргэлтээс бий болж байгаа ийм эерэг нөлөөлөл. Цаашидаа энийг тогтворжуулж эрсдэлээ буулгахын тулд саяын миний хэлдэг ерөөсөө бид үйлдвэрлэл өртөг шингэсэн дотоодын эдийн засгаа л гол

анхаарах шаардлагатай ийм бодлогод яваа. Тийм.

Б.Энх-Амгалан: Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ер нь бол өр авлага ч явж өгч байгаа л даа. Тэрийг бүгдээрээ л мэдэж байгаа. Жилээс жилд, өдрөөс өдөрт л ихсэж байна. Өнөөдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны төсвийн ерөнхий захирагч нарын 2022 оны санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийн ажлыг ярьж байна. Энэ гүйцэтгэл дээр тухайлбал гадаадад баригдсан энэ юман дээр манай аудитынхан газар дээр нь очиж үзэж харсан уу гэдэг энэ нэг ийм асуулт байна.

2 дугаарт бол Гадаад явдлын яамны, Гадаад харилцааны яамны 2022 онд хийж гүйцэтгэсэн ажил бол бас ч гэж боломжийн гэж үзэж байгаа. Их олон ч орны айлчлал байлаа. Энэ тал дээр бол боломжийн ажиллаж байна гэж бодож байна. Энэ юу байна л даа энэ гадаадад байгаа манай иргэдийн тэр тусалж дэмжүүлэх мөнгө гэнэ үү, тийм мөнгө байх шиг байна. Энэ мөнгийг яаж зарцуулаад байна вэ? Ямаршуухан хаана, хэнд, ямаршуухан зорилгоор, ямар журмаар ингэж өгч зарцуулсан мөнгө вэ гэдгийг бас нэг тодруулъя.

Нөгөө талаараа тэр Бээжин дэх ЭСЯ-нд Соёлын төв баригдсан юм байна. Энэ Бээжинд хаана баригдсан бэ? Тэгээд энэ одоо ч баригдаад дууссан юм байна л даа 22 онд. Тэгээд өнөөдөр чинь 6, 7 сар болж байна. Ингээд энэ маань хэр үр дүнтэй ажиллаж байна, ямар орон тоо энэ тэрийг бол нэмэгдсэн үү яасан бэ тэрийг нэг лавлачихъя.

Баянхонгор аймгийн тэр цэргийн ангид бол гал тогооны гал зуухны тэр байр байшинг барьсан юм байна. Тэрбум 300 сая төгрөгийн өртгөөр. Энэ маань одоо ингээд ашиглалтад орчихсон уу, ямар байгаа вэ? Тэгээд энэ та нарын

зарласан энэ тендерүүд төсөвт өртөг нь болохоор тэрбум 500 ч гэдэг юм уу, тэрбум 600 байдаг. Нөгөө яг гүйцэтгэсэн гүйцэтгэл тендер шалгаруулалт нь арай жосоохон доогуур дүнтэй байна. Яг энэ хэмжээндээ нөгөө мөнгөний үнэ хани уначихсан ийм байгаа яг чанартай юм хийж чадсан уу, үгүй юу гэдэг ийм асуулт байна.

Нөгөө талаар энэ БХЯ-ны энэ төсөв юмыг харахад бол дандаа л тийм нэг юунууд л байна л даа. Нэг ойр зуурын юмнууд байна. Яг нөгөө зэвсэглэл техниктээ анхаарсан, тийм өөрчлөлтөд анхаарсан ийм юм цаашид байгаа юу үгүй юү? Тэгээд маш их олон хүнийг ингээд үг хэлж, үзэл бодлоо илэрхийлэнгүүт амыг нь хаагаад дуугүй болгоод ингэх юм. Тэгсэн мөртөө энэ дайныг дэмжиж байгаа ч юм шиг ийм жагсаал цуглаан болохоор тэр үлгэр жишээ үлээвэр явах нь уу, тийм тэр хүмүүс нь очоод хөгжим тоглоод урд нь ингээд алхаад яваад байх юм. Тэр мөнгө төгрөг санхүүжилт хаанаас гардаг юм бэ? Энийг хэн ингэж зөвшөөрөл өгч хийдэг юм бэ? Бид нар чинь Үндсэн хуульдаа дайныг дэмжихгүй гэгчихсэн ийм л улс орон шүү дээ. Энэ тэр БХЯ-ных уу эсвэл бас ямар цэргийн анги нэгтгэлийн ийм юм яваад байна вэ, хэний зөвшөөрөлтэйгөөр явдаг юм гэдэг ийм зүйлийг бас тодруулмаар байх юм. Нөгөө талаар, юу ч гэсэн асуултад хариултаа авчхаад дараа нь тодруулъя.

Б.Энх-Амгалан: Эхний асуултад ГХЯ-ны ТНБД Анхбаяр хариулъя. Дараа нь БХЯ-ны ТНБД, бригадын генерал Ганхуяг бэлдэж байгаа. Анхбаяр даргын микрофоныг өгье, 1 номерын микрофон.

Н.Анхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн амгаланг айлтгая. Ганбат гишүүний асуултад хариулъя. ГХЯ-ны ТНБД Анхбаяр. Гадаадад баригдсан барилгыг аудит очиж үзсэн үү гэж. 2022 онд Бээжинд ЭСЯ-ан дээр Соёлын төв байгуулсан. Аудит жилд хийдэг ээлжит аудитынхаа шалгалтыг хийх явцдаа барилгын үйл ажиллагаатай бүрэн танилцаж, ном

журмын дагуу болсон байна. Ганцхан зөвлөмж өгсөн. Өгсөн зөвлөмж нь мэдээллийн аюулгүй байдлынхаа холболт дээр анхаараарай гэдэг зөвлөмж өгсөн. Одоо бид нар энэ дээр зохих арга хэмжээ аваад ажиллана.

Соёлын төв хаана баригдсан бэ гэвэл бид нар нэлээн судалж суух орны хууль тогтоомж байгаа боломжид нь харгалзаж үзэж байгаад гадуур түрээслэх бололцоо байсан, улсын төсөвт хөрөнгө оруулалт батлагдсан ийм 2 хувилбараас бид нар нэгэнт батлагдсан мөнгийг үр ашигтай буюу үр дүнтэй Төсвийн тухай хуулийнх нь хүрээнд зарцуулах ёстой гэдэг үүднээс ЭСЯ-ныхаа хашаан дотор, тэгэхдээ олон нийт орж гарах, нээлттэй ийм боломжтой байдалар барьж байгуулсан. Соёлын төв үндсэндээ 2022 оны 9 билүү, 10 сард үндсэндээ үйл ажиллагаа эхэлсэн. Түүнээс хойш бол нэлээн олон соёл урлагийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж байгаа. Тохижилтыг бүрэн хийсэн байгаа. Өөрөөр хэлбэл соёлын төвийг барьсан зорилгодоо бид нар хүрч ажиллаж байгаа гэж үзэж байна.

2 дугаар асуулт гадаадад байгаа иргэдэд туслах хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан, сангийн зарцуулалт ямар байна гэж. 2002, 2022 оны улсын төсөвт 200 сая төгрөг туссан. 83 иргэн өргөдөл гаргаснаас шаардлага хангасан буюу зориулалтынх нь дагуу 68 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн байна. Үндсэндээ 100 хувийн зарцуулалттай. Жишээ дурдахад Украйнаас Украйнд үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол оронд ирсэн 4 иргэнд дэмжлэг үзүүлэх, Орос, Чех, Польш гээд 16 иргэний шарилыг чанд чандарлах, эх оронд нь ирүүлэх гэх мэтчилэн яг Иргэдэд туслах сангийн журмын дагуу шаардлага хангасан зориулалтынх нь дагуу энэ мөнгийг зарцуулж байгаа. 2023 оны төсөвт 400 сая төгрөг буюу та бүхний дэмжлэгтэйгээ төсөв 2 дахин өссөн байгаа. Үргэлжлүүлэн журмын хүрээнд зарцуулж байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Б.Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна, ирцэд бүртгээрэй. БХЯ-ны ТНБД, бригадын генерал Ганхуяг асуултад нэмж хариулна. Та тэр Баянхонгорын асуудал, тэр нэг жагсаал цуглаан дээр БХЯ төсөв гаргасан юм уу, үгүй юм уу гэдэг дээр нэг тодорхой хариулчхаарай. Ганхуяг даргын микрофоныг өгье, 4 номерын микрофон.

Д.Ганхуяг: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Баянхонгорт 1,3 тэрбумаар цэргийн гал тогоо баригдсан, ашиглалтад ороод бол явж байгаа. Жагсаал цуглаантай холбоотойгоор бол манайхаас бол гарсан төсөв байхгүй. Албан ёсны зөвшөөрөл бол байхгүй. Зүгээр тухайн үед тэтгэвэрт гарсан манай цэргийнхэн дүрэмт хувцсаа өмсөөд ингээд асуудал үүсгэсэн. Тэр төрийн бус байгууллагуудад нь бол анхааруулгыг нь бол өгсөн байгаа.

Төсвийн хувьд бол хөрөнгө оруулалтын хувьд бол үнэхээр энэ салбарт зэвсэг техникийг шинэчлэх төсөв бол шаардлагатай. Хамгийн сүүлд 2009 онд 2 нисдэг тэрэг хөрөнгө оруулалтаар авсан байдаг юм. 22 онд сумны үйлдвэрийн төсөв бол суусан. Энэнээс өөр бол батлагдсан төсөв байхгүй. Үнэхээр зэвсэг техникийг бол шинэчлэх шаардлагатай. Гэсэн хэдий ч бид бол зүгээр суугаагүй, үндсэндээ 500 гаруй тэрбум төгрөгийн өртөгтэй тусламжаар зэвсэг техникээ шинэчлээд явж байгаа. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: ЭСЯ-ны хашаан дотор бол хэр зэрэг оновчтой байдаг юм бол? Тухайн орныхоо иргэдэд зориулаад нөгөө Монгол орноо сурталчилна гэдэг чинь. Тэр тал дээр жоохон анхаармаар л юм байна.

Нөгөө тал дээр бол энэ консулуудын үйл ажиллагаа манай иргэд нөгөө сая жуулчин ч билүү, 40 сая билүү,

400 сая жуулчин хүлээж авна гээд байгаа. Тэр визний хураамжтай байна уу, тэр мөнгө төгрөг ямар мөнгө төгрөг орж ирдэг юм бэ, хаана нь яаж зарцуулдаг юм гэсэн 22 онд хэр зэрэг мөнгө цугларав гэсэн ийм асуулт байх юм.

БХЯ-ан дээр гэхэд яахад манай цэрэг офицеруудын энэ хувцас бол үнэхээр тааруу байна лээ шүү. Ингээд харж байхад. Хамгийн чанаргүй муу материалаар хийдэг юм уу яадаг юм тэгээд. Одоо энэ гадна, дотнын хүмүүс ирж байна. Ингээд тэр өмссөн хувцсыг нь зогсож байгаа энэ тэрийг нь харахад бол их л нүүр ичмээр улаймаар байдаг. Өчнөөн сая төгрөг энэ нүүрс энэ юм татвар төлөгчдөөс орж ирж байдаг. Нэг хэдхэн цэрэг байгаа. Тэрийгээ нэг олигтойхон хувцаслаж чадахгүй нэг ийм нөхцөлд байна. Тэр.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Анхбаяр дарга эхлээд хариулъя ГХЯ-ны ТНБД, 1 номерын микрофон.

Н.Анхбаяр: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт ороод цахим визийг нэвтрүүлсэн. Виз олгох ажиллагаа буюу ажиллагаа 2 хэлбэрээр буюу уламжлалт цаасаар хандаж дээд Дипломат төлөөлөгчийн газар очиж визээ биечлэн авах. Нөгөө хувилбар нь цахим виз авч байгаа. Цахим визийн системийн хөгжүүлэлт хэвийн хэрэгжээд өнөөдрийн байдлаар ажиллагаа бол хэвийн явж байна. Өнгөрсөн оны тухайд улсын төсөвт ГХЯ 10 тэрбум төгрөг төвлөрүүлэх ёстойгоос үндсэндээ 7,9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байгаа. Дийлэнх нь визийн орлого гэж ойлгож болно. Яагаад төсөв, төсвийн төвлөрүүлэлт хүрээгүй гэхээр бид нөгөө цахим визийнхээ системийг Гадаад яамны багцаас аваад Хууль зүйн яам буюу гадаад иргэний Гадаад иргэн, харьяатын газар луу шилжүүлчихсэн учраас яг цахим визээр олсон орлогын задаргаа бол тухайн газраас гарах байх. Ийм мэдээлэл өгье.

Б.Энх-Амгалан: БХЯ-ны ТНБД, бригадын генерал Д.Ганхуяг хариулъя, 4 номерын микрофон.

Д.Ганхуяг: Энэ хувцасны хангалт бол үнэн. Манай төсвийн зардлыг автоматаар 50 хувь хасчихсан. Өнөөдөр бид цэргээ хооллож хүнс нь хүрэхгүй цаашид яаж энийг хангах вэ гэдэг дээр байна. Мөн хувцасны зардал бол үгүй ээ хувцсыг бол 30 хувийг нь л хангаж байгаа бие бүрэлдэхүүний. Үнэхээр хөдөө салбарт ажиллаж байгаа офицер ахлагч нар хувцсаа гандтал өмсөөд л явж байгаа. Тэгээд энэ бүгд төсвөөс хамааралтай ийм байгаа.

Б.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя.

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ Батлан хамгаалахын сайд бусад газрууд дээр бол яриа алга. Ер нь хэмнэлтийн дэглэм Хэмнэлтийн хуулийн хүрээнд яамнууд холбогдох төсвийн ерөнхийлөгчийн захирагч нар бас тодорхой хэмжээний хөрөнгө мөнгө хэмнэсэн ийм дүр зурагтай үнэлэлтүүд нь ч тийм байгаа юм байна. БХЯ-ны хувьд би бол Ганбат гишүүний хэлсэнтэй санал нэг байгаа юм. Тэгэхдээ энэ зардал мөнгө хүрэлцэхгүй байгаа, цэрэг муу хувцастай байгаа, хоол хүнсний хангамж нь тасалдчих гээд байгаа яг өнөөдрийн байдлаар бол тасалдаагүй л байна. Сүүлийн хагас 8, 9 сараас бас амаргүй болно. Энэ бол БХЯ гэхээсээ илүү энэ Засгийн газраас, Улсын Их Хурлаас шалтгаалж байгаа юм. Жил болгон яам юмаа оруулж ирдэг. Эндээс тэгээд Сангийн яамнаас эхлээд, Засгийн газраар дамжаад Улсын Их Хурлаар батлагдаад гарахдаа дандаа хасагдаж ингэж явж байгаа. Тэгэхээр энэ дээр бол бид нар цаашидаа ялангуяа манай Байнгын хороо их анхаарах хэрэгтэй гэдгийг дахиад л хэлчихье.

Энэ хэд хэдэн зүйл дээр зарлал хэмнэгдсэн байна л даа Ганхуяг даргаа. Хангамж, бараа материалын зардал,

норматив зардлууд, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гээд. Тэгээд энэ юмнуудаа жилийн явцад Засгийн газар, Сангийн яамтай яриад, одоо тэр хүрэлцэхгүй байгаа хувцасны хангамж, хүнсний хангамжийнхаа юманд зарцуулахад болохгүй байгаа гол шалтгаанууд юу байна вэ? Уг нь жоохон юм хэмнэчихсэн юм харагдаад байдаг. Тэгсэн мөртөө мөнгөө зарцуулж чаддаггүй. Ингээд хүнд байдал үүсээд байгаа. Яг энэ дээр бид нар яамаар байна вэ, Байнгын хороо яамаар байна вэ, Засгийн газар яамаар байна вэ? Хууль номд өөрчлөлт оруулаад жилийн явцад хэмнэгдэж байгаа зүйлүүдээсээ үнэхээр зайлиггүй л шаардлагатай цэрэг хоол идэх ёстой юу ёстой, нүцгэн гүйхгүй байх ёстой юу хувцастай байж байх ёстой. Тэгэхээр энэ дотор нь зохицуулдаг боломжуудыг бий болгохын тулд хууль, эрх зүйн ямар зохицуулалт хэрэгтэй байна вэ гэдэг дээр нэг хариулт өгөөч.

2 дахь асуулт бүтээн байгуулалтын ажлууд нэлээн хийж байгаа, сайн ч хийж байгаа. Жишээ нь энэ цэргийн ангиудын хийсэн тэр гал тогооны гээд 3, 4 газар хийсэн юм уу даа. Би гол төлөв манайхан цэргийнхэн өөрснөө хийсэн болов уу гэж бодож байна. Бүгд 100 хувийн ашиглалттай, чанар гүйцэтгэл бол харьцангуй их сайн байгаа. Тэгээд энэ дээр энийг нэг дурдчихъя. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого, зарлагын асуудал энэ сайдын гүйцэтгэл дотор явж байна уу, явахгүй байна уу 3 дахь асуудал, 2 дахь асуудал энэ байна. Тэр бүтээн байгуулалтын ажил хийчхээд хөлс хөрөнгө мөнгө нь дутуу орж ирсэн зүйлүүд байна уу, хаанаас шалтгаалж байна вэ гэсэн нэг ийм 2, 3 асуулт байна.

Б.Энх-Амгалан: Асуултад хариулъя. 4 номерын микрофон.

Д.Ганхуяг: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Энэ төсвийн дүнгээр ингээд харахаар хэмнэгдсэн харагдаж байгаа юм. Энэ дотор бол хөгжлийн сан жил болгон 35 тэрбумаар батлагддаг. Тэр 35 тэрбумын санхүүжилт НҮБ-аас

орж ирдэг. Тэгээд хугацаандаа орж ирэхгүй учраас гүйцэтгэл нь 35-даа хүрдэггүй, 30, 25, 26 гэх жишээтэй ингэж гүйцэтгэл гардаг учраас ерөнхий төсвийн дүнгээрээ бол ингээд хэмнэлттэй гардаг.

Бүтээн байгуулалтад орсон Ханги зам Өмнөговь таван толгой энэ бүтээн байгуулалттай холбоотойгоор үндсэндээ 20-иод тэрбум төгрөгийн авлага байгаа. Бид авлагаа хөөцөлдөөд, тооцоо нийлээд асуудлаа яриад явж байгаа. Болсон.

Б.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн тодруулъя.

Н.Энхболд: Яг хаанаас орж ирэх мөнгөнүүд ингээд хүлээгдээд, юунаас шалтгаалаад байгаа юм байгаа юм бол? Бүүр нэр устай нь хэлмээр байх юм.

Б.Энх-Амгалан: Ганхуяг даргад тодорхой хариулъя, 4 номерын микрофон.

Н.Энхболд: 20 тэрбум төгрөг чинь их мөнгө шүү дээ.

Б.Энх-Амгалан: Тийм 20 тэрбум төгрөг яг хаанах хаанахын мөнгөнүүд орж ирэхгүй байгаа юм бэ гэдгийг асууж байна.

Д.Ганхуяг: Монголын төмөр зам мөн Ханги Мандалд бүтээн байгуулалт хийсэн МТЛ гэдэг 2 газартай тооцоо байгаа. 2 газар маань санхүүжилт байхгүй, санхүүжилт орж ирэхээр энэ ондоо багтааж орлогыг шилжүүлнэ гэсэн тооцоо нийлээд явж байгаа.

Б.Энх-Амгалан: Би 3 асуулт асууя. Энэ Үндэсний аудитын газрын дүгнэлтэд ОБЕГ-т хийсэн дүгнэлтэд 82 алдаа зөрчил илрүүлж, 11 төлбөрийн акт тогтоож, 25 албан шаардлага, 46 зөвлөмж хүргүүлсэн байна гэж байна. Тэгэхээр энэ ОБЕГ энэ санхүүгийн зөрчил дутагдал ихтэй гэсэн үг үү? Энэ ямар, ямар юмнаас болсон юм бэ, энэ яагаад ингэж байгаа юм гэдэг асуултыг 1 дүгээрт асууя.

2 дугаарт ГХЯ ингээд л төсөв хүрэхгүй байна, болохгүй байна, гадна талд сууж байгаа хүмүүсийн маань цалин пүнлүү бага байна, засвар үйлчилгээ хийгдэхгүй байна, ерөөсөө хэцүү байна, нэмээд өгөөч гээд л ингээд л жил болгон л ярьдаг. Тэгээд ингээд харахаар зэрэг энэ жил төсвийн жилд ГХЯ 39,1 хувь, дипломат төлөөлөгчийн газар 11,1 хувь, хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан 2,2 хувь, Юнескогийн ажлын алба 12,6 хувиар батлагдсан төсвөөс дутуу зарцуулжээ гэж байна. Ажлаа хийгээгүй юм уу эсвэл яасан юм бэ? Энэ нөгөө иргэдэд туслах сангийн мөнгө чинь хөдлөөгүй байх юм. Энэ ковидоос шалтгаалсан уу эсвэл иргэд тусламж авахаа байчихсан юм уу? Дутуу зарцуулсан юмыг чинь ингэж асууя.

2 дахь нь тендерийн хэмнэлт 458,8 сая төгрөг боллоо гэж байна. Ямар ажил хийгдэх гэж байгаа тендер зарлагдаагүй юм бэ, эсвэл зарлачхаад буцчихсан юм уу, эсвэл хийгдсэн тендер чинь тийм бага үнээр хийгдээд та нар өндөр үнээрээ зарласан юм уу? Энэ ямар дүн юм бэ?

3 дугаарт нь хэмнэлт нийтдээ 48,1 сая төгрөгийн хэмнэлт гарлаа гэж байна. Тэгээд энэ хэмнэж болдог юм бол та нарын төсөв илүү байгаа юм биш үү? Дутуу зарцуулж болдог, хэмнэж болдог, тендерээс хэмнэж болдог юм бол та хэд маань тэгээд ГХЯ-ны төсөв хангалттай байгаа юм биш үү гэдэг л ийм дүгнэлтэд хүрэх гээд байна л даа. Энийг нэг тодорхой хариулаадхаарай Анхбаяр даргаа.

БХЯ-наас нэг юм асууя. Танай жилийн төсөв 23,6 тэрбум төгрөг байна. Батлагдсан төсөв чинь 12,3 тэрбум төгрөг байна. Та нар төсвөө өсгөж тавьчхаад ингээд 50 хувиар нь батлуулаад яваад байдаг юм уу? Эсвэл та нар Сангийн яаман дээрээ Засгийн газар дээрээ батлуулж чадахгүй ингээд тавьсан төсвийнхөө 50 хувиар баталчхаад ингээд ажлаа ч хийж чаддаггүй, юмаа ч хийж чаддаггүй сууж байдаг юм уу? Энэ хэний хариуцлага вэ?

Би бол юу гэж ойлгож байна гэхээр та нар өөрсдийнхөө энэ төсвийг хамгаалж гарч чадаагүйгээс болоод ингээд төсөв чинь 50 хувиар батлагдчихаад, та сая тэгээд цэргүүдийн хоол унд, хувцас хунар яриад сууж байна гэж би ингэж ойлгож байна. Энэ тал дээр нь тайлбар өгөөдхөөч. Ийм нэг хэдэн асуулт байна. Эхлээд ОБЕГ хариулах уу, аудит хариулах уу? Аудит хариулъя, 3 номерын микрофон.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. ОБЕГ-ын төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудит төсвийн гүйцэтгэлээр хязгаарлалттай гэсэн санал, дүгнэлтийг өгсөн байгаа. Нийтдээ ОБЕГ-ын төсвийн шууд захирагч дээр нийт 18,1 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Эндээс бид бас аудитын явцад нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой алдааг залруулаад зөрчил дээр нь аудитын Төрийн аудитын тухай хууль болон аудитын стандартын дагуу албан шаардлага, төлбөрийн акт тогтоох энэ арга хэмжээг авсан байгаа.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагч буюу Шадар сайдад төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтыг энэ ОБЕГ дээр онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна гэсэн албан шаардлагыг хүргүүлсэн байгаа.

Б.Энх-Амгалан: Тэгэхээр эд нар бол санхүүгийн зөрчил дутагдал гаргадаг гэсэн үг юм байна тийм? Анхбаяр дарга хариулъя, 1 номерын микрофон.

Н.Анхбаяр: Энх-Амгалан даргын асуултад хариулъя. 1 дүгээрт төсвийг зарцуулалтын хуваарь нь гаргаад ирэхээр яах аргагүй хэмнэлттэй юм шиг харагдаад байгаа. Гэхдээ батлагдсан зориулалтынх нь дагуу хуулийн хүрээнд зарцуулах ёстой 1 дүгээр зарчим, 2 дугаарт хэмнэлтийн горим, 3 дугаарт батлагдсан төсөв болгоныг үр өгөөжтэй

ажилд нь зарцуулах гэсэн ийм л зарчмын хүрээнд хэмнэлтүүд гарч байгаа болохоос биш дутуу батлагдаж байгаа гэж бас үзэхгүй байгаа.

23 оны тухайд та 3 тодорхой асуудалд хөндсөн. 1 дүгээрт Иргэдэд туслах санд 200 сая төгрөг батлагдсанаас 12 сарын 31-ний байдлаар гүйцэтгэл 195,5 сая төгрөгийн зарцуулалт, тэгээд нөгөө мөнгөн дүн нь бага учраас хувь нь бас ингэж харагдаад байх шиг байна. Түүрүүн хэлсэн 68 иргэний өргөдөл. Зарим тохиолдолд энэ төсвийн санхүүгийн жилийн төгсгөлд иргэдийн мэдээлэл санхүүгийн данс гээд буцалт хийгддэг ийм он дамнасан ганц нэг юм байдаг учраас энэ дээр он дамнасан гүйцэтгэлийн асуудал байх шиг байна.

Байртай холбоотой хөрөнгө оруулалтын асуудал дээр соёлын төвд 1,6 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс зарцуулсан дүн нь 1 тэрбум 599.99 сая төгрөг байгаа. Хөрөнгө оруулалтын тухай урсгал зардлын тухайд 3,4 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс бид нар Брюссель дэх Брюссель, Вена, Вашингтон, Дели, Софи, Каир, Парис, Улаан-Үүд, Эрхүү гээд үндсэндээ 8, 9 газрын урсгал буюу их засварыг үүн дотор би Вашингтоны ЭСЯ, Венын ЭСЯ, Парисын ЭСЯ-ны засварыг бүүр онцгойлон хэлмээр байна. Гүйцэтгэл 3 тэрбум 246,9 сая төгрөг, 3 тэрбум 246,9 сая төгрөг. Үлдэгдэл нөгөө машин тэрэг, техник тоног төхөөрөмжийн хувьд бол бас гүйцэтгэл 3 тэрбум 71 сая төгрөг. Өнгөрсөн оны тухайд харин энэ машин дээр юу болсон бэ гэхээрээ зах зээл дээр машины олдоц байгаагүй учраас ганц нэг ДТГ-д худалдан авахаар төлөвлөсөн машинууд олдоцгүй болсон учраас бид нар энэ батлагдсан төсвийг ийм дутуу зарцуулалттай ингэж гараад байгаа юм гишүүнээ.

Тийм учраас Засгийн газар дээр ч гэсэн энэ бид нарын төсөв мөнгийг нэмэхтэй холбоотой асуудал ярьж байгаа. Ирэх оны төсвийн тухайд бид нар 24 оны төсвийн тухайд ер нь Засгийн

газрын хуралдаан дээр нэг л зарчим тогтсон. Нэг жил болгон ядаж нэг том өөрийн өмчлөлийн байраа зассан шиг засаач гэдэг ийм тэмдэглэл гараад, тэр тэмдэглэлийнх нь энэ хүрээнд би сая онцолж хэлж байгаа Вашингтон дээр 1 аравны үндсэндээ 4 тэрбум төгрөгийн засвар хийсэн. Вашингтон дахь ЭСЯ-ны байрыг бид нар 90 оны эхээр авсан, тэрнээс хойш огт засвар хийгдээгүй байж байгаад засвар хийсэн, бүрэн сайн болсон. Ойрын хугацаанд асуудалгүй болсон. Ирэх жил Женевийг оруулж ирэх байх. Дээрээс нь өөр ямар газрууд байна вэ гэх мэтчилэн. Өөрөөр хэлбэл ГХЯ батлагдсан төсвөө хуулийн хүрээнд, зориулалтынх нь дагуу үр бүтээлтэй, үр ашигтай мөн Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу ажиллахыг зорьж ажиллаж байгаа. Баярлалаа танд.

Б.Энх-Амгалан: Би тэр дутуу зарцуулалтыг бол ойлгогчихлоо, хэмнэлтийг бол ойлгогчихлоо. Энэ тендерийн хэмнэлт гээд 458,8 сая нь юу юм бэ? 458.8 сая байна шүү дээ. 31 гээд хаачихдагаараа тэгээд байгаа юм уу тийм ээ?

Ч.Ганбат: Валютын ханишийн зөрүү нь орж ирсэн байгаа.

Б.Энх-Амгалан: Ойлголоо. БХЯ Ганхуяг дарга хариулъя, 4 номерын микрофон.

Д.Ганхуяг: Төсвийн хувьд бид бол хариуцсан чиглэл чиглэлийнх нь хүнсний хэлтэс, хувцасны хэлтэс ингээд чиглэл, чиглэл хариуцсан хэлтэс бүгд очиж Сангийн яаман дээр бол тайлбараа хэлдэг, хэрэгцээгээ гаргаж өгдөг, ойлгуулдаг. Тэгээд төсөв яг ирэхээрээ ингээд хасагдчихаад ирдэг. Хамгийн наад захын жишээ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр орсон бид 23 онд мянган оюутан цэрэг авна гээд байж байхад тэгээд автоматаар бидэнтэй ярилгүйгээр 100 болгох жишээтэй. Тэгээд Ерөнхий сайд оюутан залуустай уулзахад санал гаргаад, буцаад тэр төсвийг нь тавиад 1500 болгож авах жишээтэй.

Бодит байдал ингэж явж байгаа. Сүүлийн үед бол Сангийн яамныхантай ч уулзаж ер нь чадахгүй байгаа, тэр Төсвийн газрын даргатай бол уулзаж чадахгүй. Манайхан чадахаараа л очдог, хүлээж авахгүй ийм л байдалтай байгаа.

Б.Энх-Амгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Би нэг зүйл хэлье. БХЯ энэ жил төсвийн, Ганбат гишүүн. Ганбат гишүүнээр тасаллаа. Дараа нь би үг хэлье Ганбат гишүүн үгээ хэлье.

Д.Ганбат: Ер нь бол энэ төсвийн гүйцэтгэлийг сонслоо. Тэгээд нөгөө авлигад идэгдсэн улс орон ямар байдаг вэ тэрний л нэг жишиг л байна л даа. Тухайлбал би энэ дээр бол манай цэрэг офицеруудын хувцасны асуудлыг ярих гээд байна. Үнэхээр харваас л мэдэгдээд байгаа байхгүй юу. Хамгийн чанаргүй материалаа хэрэглэсэн, тэр үүрэг гүйцэтгэх явцад өмсөх хувцас байдаг юм уу, үгүй юм уу, тэр нь шаардлага хангах уу, үгүй юү гэсэн ийм юм байна. Энэ дээр анхаарах цаг болчихсон. Цааш цаашидаа. Тэгээд яагаад Сангийн яам нь тэр энэ БХЯ-ны энэ талаар ярилцах гэсэн энэ юмнуудыг тэгээд хүлээж аваад хоорондоо ярилцаад ингээд зохицуулж болдоггүй юм бэ? Энэ чинь нэг л Засгийн газар байгаа биз дээ, нэг л улс байгаа биз дээ.

Нөгөө талаар энэ манай Гадаад явдлын яам бас хойд хөрштэйгөө бас их нэлээн сайн ажилламаар байна. Тухайлбал бид нар тэр гаалийн тарифын хувьд бол маш их өндөр байгаа шүү дээ. Бараг 30-аад жил ингэж явж эхэллээ. Энэ талаар нөгөө манай хойд хөршүүд маань ОХУ бол одоо нааштай юм ярьдаг болчихсон юм шиг байна гэж би ойлгоод байгаа юм. Арай ч ингэж болохгүй юм бид нар хоорондоо ярья. Тухайлбал худалдааны алдагдал их байна, энийг бид нар бас өөрчилж гэсэн зүйлийг би эхнээсээ ярьж эхэлж байна гэж ойлгож байна.

Тэгээд бас л манайхны хийж байгаа ажил. Тэр урд хөршид өөрийнхөө соёлыг Монгол Улсаа сурталчилъя гэдэг юмыг ЭСЯ-ны хашаан дотор барихаараа яах вэ дээ. Энэ чинь элчин сайдын Монгол Улсын ЭСЯ гэдэг чинь Монгол Улсын нутаг дэвсгэр л байхгүй юу. Тэр лүү чинь гаднын тэр Бээжин хотод байгаа Бээжингийн иргэд Бүгд Найрамдах Хятад Ард улсын иргэд бол чөлөөтэй үзэж хараад, зорчоод ингээд иргэдээ ингээд яах ийм боломжгүй шүү дээ. Бараг л би ЭСЯ-ныхаа хашаан дотор барьсан болов уу л гэж бодож байсан. Яг л тийм л байна л даа. Иймэрхүү оновчгүй хөрөнгө оруулалтууд ийм ажлыг ингэж бас хийгээд хэрэггүй. Энэ бол нэг их үр дүнтэй ажил болж болоогүй байна л гэж үзэж байна би. Энэ зүйлүүд дээрээ анхаараарай.

Нөгөө талаар тэр цэргийн хувцас формыг хэрэглэх тал дээр бол бас анхаарах ёстой, тэр дүрэм журам ч байдаг байх. Тэгээд хэн дуртай хүмүүс нь тэр Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн форм хувцсыг хэрэглээд, энэ гадаа гудамжинд янз бүр болоод ингээд явах нөхцөл байдал байхгүй гэж ойлгож байна. Хэрвээ тийм байдаг бол тэрийг хязгаарласан тийм юм хийхгүй бол бас гадна, дотнын улс орнуудад, энэ дотор байгаа манай бусад Монгол Улсын иргэдэд ч гэсэн буруугаар ойлголт төрүүлж байна. Тэгээд та бүхэн тухай тухайн үед нь гарч ирээд наад мэдэгдлүүдээ хийж байх ёстой. Энэ юм чинь аягүй байхгүй байна шүү гэдгийг бас анхааруулъя. Товчхон ийм байна.

Үүнээс гадна бол манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд бол энэ гол, гол газруудад засвар хийсэн юм байна. Тухайлбал Вашингтон, Вен гээд. Энэ бол зөв оновчтой болсон байна. Сайн засвар хийсэн гэж өөрөө ярьж байх шиг байна Гадаад явдлын яам. Тэрийг бид нар бас үзээд хараад бас ингээд очиж харахад бол, яг үнэн юм уу эсвэл бас очиж чадахгүй эд нар гэсэн үүднээс ингэж яриад байгаа юм уу. Тэр аудитын

дүгнэлтэд ямар үр дүнтэй байгаа талаар ийм юм бас алга байна шүү. Очоод үзсэн гэхэд ЭСЯ-ны хаашаан дотор барьсан байна ийм үр дүнтэй байна, цаашидаа ингээж ашиглах боломжтой юм байна гэсэн ийм юмнуудыг манай аудит ерөөсөө ярихгүй юм. Тэгээд нэр зүүгээд л нэг аудитын дүгнэлт орсон маягтай ийм үлбэгэр. Нэг эрх баригчид ч юм уу, энэ Засгийн газарт ч юм уу нийцүүлсэн ийм л юм ярих юм. Энийгээ одоо та нар боль.

Та нар бол яг л татвар төлөгчдийн мөнгийг яаж зарцуулж байна. Энэ дээр бол одоо гарах хэрэгтэй шүү дээ. Тэртээ тэргүй Монгол Улс бол авлигад идэгдчихсэн ийм нөхцөл байдалтай байгаа гэдгийг орон даяараа л мэдэж байгаа шүү дээ. Тэгээд энд болж байгаа бүтэж байгаа юм шиг юмыг аудит нь яриад гарчих юм. Тэгээд нэг юу билээ тэр ОБЕГ дээр гарч байгаа зөрчлийг хар. Манай Байнгын хороонд байдаг байгууллага, асуулаа, тэрэнд нь хариулж байгаа ч хүн алга. Тэгээд л гадна, гаднаас өчнөөн төчнөөн тэрбумаар авсан тэр нисдэг тэрэг нь сургалтынхаа явцад унаж л байдаг. Тийм үнэтэй цайтай хөрөнгийг чинь тэгж устгах биш тэр тернежер дээр дадлага хийгээд, дараа нь очиж сургуулилтаа хийх ёстой шүү дээ. Тэгээд ийм зүйлийг нөхдүүдэд анхааруулъя. Юу билээ, нөгөө төрийн мөнгө уйлдаггүй гэдэг шиг л, татвар төлөгчдийн мөнгө уйлдаггүй гэдэг шиг л юм болоод байна уу, үгүй юу. Товчхон юм байна.

Б.Энх-Амгалан: Баттөмөр гишүүн саналаа хэлье.

Б.Баттөмөр: Монгол Улсын Их Хурлаас баталсан үндэсний, тийм Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал гээд нэг баримт бичиг байгаа. Энэ бол өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөх гэж байгаа. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс энэ үзэл баримтлалыг шинэчилж гэсэн ийм үйл ажиллагаа явагдаж, тодорхой ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа юм байна лээ.

Нэгэнт мөрдөгдөж байгаа энэ Аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд ингээд аваад үзэхээр энэ дотор эдийн засгийн аюулгүй байдал гэж нэг их том заалтууд байж байгаа. Яг тэр заалтуудыг өнөөдөр ингээд аваад үзэхээр бол бүрэн алдагдчихсан байгаа. Тэгээд энэ манай энэ төсөв танилцуулж байгаа энэ танилцуулга дотор яах вэ зүгээр нууц ч гэдэг юм уу ийм байдлаараа оруулаагүй байх л даа. Тэгэхдээ ил ярьчих юмнууд зөндөө байгаа л даа. Жишээлбэл худалдааны эргэлттэй холбоотой асуудал байна шүү дээ тийм ээ. Нэг хөрштэй нь 37 тэрбум төгрөгийн ашигтай худалдаа хийгээд байгаа мөртөө, нэг хөрштэй нь 22 тэрбум долларын, уучлаарай би түрүүн 37 тэрбум доллар гэж хэлэх гэж байгаа юм. 37 тэрбум долларын ашигтай, нөгөө хөрштэй нь 22 тэрбум долларын алдагдалтай ийм худалдаа хийсэн байгаа. Тэгэхээр энэ аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал гэдэг үгээ нөхдүүд энэ үгийг бол хэлж байх ёстой, бодож байх ёстой, ажиллах ёстой энэ мөрөөр. Энэ чинь бид л ажиллах ёстой шүү дээ. Түүнээс биш өөр хүн ирж энийг ярихгүй, хийхгүй шүү дээ.

Сая тэр Ганбат гишүүний хэлж байгаатай би санал нэг байна. Ялангуяа энэ хойд хөрштэй харилцах харилцаанд өөрчлөлт хийх ёстой. Тэр нэг харилцаанд саад болоод байгаа нэг хэлэлцээр гэдэг юм уу даа тийм юм байгаа. Тэрийг өөрчлөх, ялангуяа Монголд үйлдвэрлэсэн ялангуяа энэ ХАА-н бүтээгдэхүүн ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн бол хойд хөршид том зах зээл байна шүү дээ. 90 оноос хойш энэ харилцаа бол байхгүй болчихсон ийм байгаа. Тийм учраас би энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр энэ асуудлыг бол зориуд ярьж байгаа.

Сая урд хөршид Ерөнхий сайдын хийсэн айлчлалын үед бол бас нэлээн ахиц дэвшилүүд гарч ирж байна. 3 дахь ертөнцтэй харилцах, эдийн засгийн олон тулгууртай болох энэ чиглэлд бол нэлээн боломжууд эвтэйхэн юмнууд яригдлаа.

Энэ дээр бид үргэлжлүүлж сайн ажиллаж, үр дүнд хүрэх шаардлагатай гэж ингэж үзэж байгаа юм.

Дараагийн асуудал энэ өрийн асуудал байгаа шүү. Яах вэ өнөөдөр дефолтоос бол бага зэрэг ангижирсан боловч сая яах вэ тэр своп хэлцлийг нь сунгаад жоохон холдож л байна л даа. Гэхдээ Монголын эдийн засагт 2 аюул байгаа. 1 дүгээрт нь энэ үнийн өсөлт, инфляц. 2 дахь нь дефолт. Дефолт бол бид нараас их холдоогүй байгаа шүү. Энэ 2 дээр бол анхаарах ёстой. Энэ төсвийг бол нэгэнт төсөв ярьж байгаа учраас төсвийг бид төлөвлөхдөө бол гүйцэтгэлд суурилах ёстой. Энэ 22 оны гүйцэтгэлээс бид нар 23 онд нэг их тийм сургамж аваагүй. 24 оны энэ төсвийг хийхдээ энэнээсээ маш их том сургамж авах ёстой. Тэр хэмнэлттэй байх ёстой төсөв, үр ашигтай байх ёстой, энэ чиглэлд нь бид нар голлож анхаарч ажиллах ёстой гэж ингэж ойлгож байгаа. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа тэмдэглэж аваарай. ОБЕГ санхүүгийн сахилга батлаа сайжруулъя. Төсвийн ерөнхийлөн захирагчдаа хэлээрэй. Энэ олон алдаа дутагдал, зөрчил, шаардлага, зөвлөмж хүлээж авчхаад тэгээд ингээд зүгээр суугаад байж таарахгүй шүү. Эндээсээ сургамж аваарай. Байнгын хороон дээр мэдээлэл сонсоно гэдгийг нь хэлээрэй. Тэгээд энэ олон санхүүгийн зөрчил дутагдал гаргачхаад, тэгээд ингээд тайланд аудитын тайланд орж ирчхээд ингээд суугаад байдаг байж таарахгүй. Тийм учраас 1 дүгээрт энийг онцгой анхаар.

2 дугаарт Байнгын хороо хуралдаад, мэдээлэл сонсоод ГХЯ-тай холбоотой 02 тоот тогтоол Засгийн газарт чиглэл өгөх тогтоол гарсан. Тогтоолын хэрэгжилтийг биелүүлж ажиллахад ГХЯ нэлээн анхаарч ажиллаарай. Эргэж сонсоно.

БХЯ-тай холбоотой 04 тоот тогтоол гарсан Засгийн газарт чиглэл

өгөх тухай. Энэ асуудал бол энэ оны 4 дүгээр улирал, дараа оны 1 дүгээр улиралд Байнгын хороон дээр танилцуулагдана. Дахиад ингээд бид нар ингээд хөөцөлдөөд явсан чинь бүтэхгүй байна, тэгээд ингээд болсонгүй. Сангийн яам хаалгаа тайлж өгөхгүй байна, хүнтэй уулзаж чадсангүй гэдэг ийм юм Засгийн газар кабинетын зарчмаар ажилладаг Засгийн газар хоорондоо тийм юм ярихгүй шүү. Хэрвээ бид нар цэрэг армиа тэжээж чадахгүй бол хүний арми тэжээнэ гэдэг нэг тийм үг байдаг юм байна лээ шүү. Тангараг өргөсөн цэргийнхээ албан хаагчдыг тэжээж чадахгүй, хувцаслаж чадахгүй байна гэдэг бол байж болохгүй асуудал. Тийм учраас энэ асуудлыг БХЯ-ны удирдлагууд анхаарч, төсөв батлагдахаас өмнө эргэж Байнгын хороон дээр энэ асуудлыг яриарай гэдгийг хэлье.

Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт гарна. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Баделхан гишүүн байдаг юм байна. Баделхан гишүүнийг томилъё. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

12.04 цаг

Хоёр.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн асуудал дээр оролцох ажлын хэсгийн гишүүдийг дуудаарай. Монгол Улс

Азийн хөгжлийн банк хоорондын аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Болдын Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд, Батсүхийн Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Даваасамбуугийн Эрдэнэбаяр эдийн засгийн, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга, Цэндгомбын Болорчулуун хөдөө, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Болорчулуун дарга байна уу? Болорчулуун даргыг дуудаарай. Эрдэнэбатын Батболд БХБЯ-ны Хөгжлийн бодлогын бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга байна уу? Байгальмаагийн Одонтуяа Сангийн яамны Санхүү бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга байна уу? Байна. Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хороон дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улс Азийн хөгжлийн банк хоорондын аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурах тухай Ерөнхий сайдын захирамжийн төслийг Улсын Их Хурлын Эдийн засаг, Төсөв

болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор тус тус хэлэлцэн дэмжсэн. Үүний дагуу Ерөнхий сайдын 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар захирамжаар Сангийн сайд миний бие тус санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгосны дагуу Азийн хөгжлийн банкны 2 дугаар сарын 28-ны өдөр 2 талаас хэлэлцээрт гарын үсэг зураад байна.

Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол болон Шинэ сэргэлтийн бодлогын хот хөдөөгийн сэргэлт гэсэн Монгол Улсын дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нягт нийцэж байгаа бөгөөд хүнсний 19 гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болоход чухал ач холбогдолтой хөтөлбөр юм.

Цаашилаад тус хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд аймаг болон сумын төвүүдийн дэд бүтцийг хөгжүүлэх. Үүнд төвлөрсөн дулаан хангамж, ус зайлуулах хоолой, бохир усны хоолой зэрэг аймаг, сумдын дэд бүтцийн дутагдлыг шийдвэрлэх, агро бизнес эрхлэгчдэд тулгардаг санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх үүднээс зах зээлээс бага хүүтэй, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, хугацаа ихтэй зээлийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хүргэх, нэмүү өртөг шингэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжихийн зэрэгцээ бэлчээрийн доройтлыг арилгах зорилгоор малчдын бэлчээрлэх дадлыг сайжруулах, мөн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтэд шаардлагатай төлөвлөгөө, арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрийн паркийн менежменттэй холбоотой төр, хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтыг судлах зэрэг болно.

Энэхүү санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд урьд өмнө нь байгаагүй өндөр дүнтэй буюу нийт 78 сая ам.долларын буцалтгүй тусламжийг зээлдэгч байгууллагуудаас олгохоор байгаа. Түүнчлэн улс Уур амьсгалын ногоон сангаас авч буй зээл нь тэг хувийн хүүтэй, 10 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 40 жилийн эргэн төлөх нөхцөлтэй, мөн АХБ-аас авч буй зээл нь 2 хувийн хүүтэй, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, 25 жилийн эргэн төлөх нөхцөлтэй бөгөөд Европын хөрөнгө оруулалтын банкнаас авч буй зээл нь тогтмол 2,92 хувийн хүүтэй, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 25 жилийн эргэн төлөх нөхцөлтэй нийт 550 сая ам.долларын зээлийн хүү зээлийн эх үүсвэртэй болно.

Тус санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг байгуулснаар Монгол Улс нь хөтөлбөрийн санхүүжилтийг заавал авч ашиглах үүрэг хүлээхгүй бөгөөд хөтөлбөрийн эх үүсвэрийг тухайн олон улсын байгууллагууд Монгол Улсад олгохоор хуваарилалт хийн хадгалж байгаа хэлбэр болно. Түүнчлэн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад Монгол Улс санхүүжилт хүсэх хууль зүйн үүрэг хүлээхгүй ба зээлийн гэрээ байгуулагдаагүй тохиолдолд хөтөлбөрийн хүрээнд үүссэн эх үүсвэрийг цуцлах бүрэн эрхтэй. Энэхүү санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай. Тиймээс Соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Сангийн сайд миний бие гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд бүх яамдын саналыг авч тусгасан болно.

Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2023 оны

5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн бөгөөд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж өгөхийг зөвшөөрнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Жавхлан сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Наранбаатар гишүүнээр тасаллаа. Дараа нь би асуулт асууя. Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Энэ төслийг бол зээлийн төслийг бол хэлэлцээрийг бол дэмжиж байна. 25 жилийн хугацаатай жилийн 2 хувийн хүүтэй гэж ойлгож байгаа шүү дээ тийм үү? Энэ бол зүйтэй. 17 аймагт хэрэгжих юм байна, 52 сум хамрагдах юм байна. Нийт зээлийн хэмжээ 735 сая доллар. Эхний үе шатад бол 270 сая долларыг нь авч хэрэглэх юм байна гэж.

Тэгээд нүүрстөрөгч бага ялгаруулдаг гээд л ингээд л яах вэ зүгээр олон улсын хэллэг чиг хандлага л ийм байгаа байх. Манай улс чинь нүүрстөрөгч бага ялгаруулдаг гээд л зээл янз бүрийн юм аман дээрээ ярьдаг мөр мөртөө энэ нүүрстөрөгч их ялгаруулдгийг л дэмжээд байгаа шүү дээ сүүлийн үед. Хортой бодис ялгаруулж байгаа юмыг л дэмжээд байгаа. Энэ дотор дотор нь ингээд үзэхээр нөгөө хуваарилалтын шог байна гэдэг шиг хуваарилалт дээр бас ярих юмнууд байна. Тухайлбал энэ 395,7 сая доллар дотор цахилгаан, дулаан, авто зам, ус зайлуулах энийг гаднаас зээл авч хийх юм уу? Тэр хог хаягдлыг дахин боловсруулах ч байж болдог юм гэж үзэхэд. Нэг ийм юм явж байх юм.

Дараагийн асуудал энэ Засгийн газраар дамжуулан 50 сая долларын зээл дамжуулан зээл зээлийн эрсдэлийн батлан даалт гэж байгаа юм. Яг энэ юу гэсэн үг юм бэ, энийгээ тайлбарлаж өгөөч гэж.

Дараагийн асуулт бол юу гэхээр 180 орон нутгийн иргэдэд суурилсан

малын эрүүл мэндийн ажилтан сургах. Энийг заавал гаднаас зээл авч хийх юм уу? Яагаад дотооддоо энийг хийж болдоггүй юм бэ?

Уур амьсгалд тэсвэртэй ХАА-н бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах. Заавал зээл авч хийх юм уу?

Бүсчилсэн хөгжлийн үндэсний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх бас зээл авч хийх юм уу? Бид яриад байгаа шүү дээ. Зээлийг бол авч болно. Үр өгөөж хэрэгтэй зүйлд нь заръя гэж. Монгол Улсад энэ ялангуяа ХАА-н салбарт бол энэ зээлийг авч хэрэглэх маш их олон салбарууд байгаа шүү дээ. Энд тэр эрчимжсэн ХАА-г хөгжүүлэх, МАА-г хөгжүүлэх, газар тариаланг хөгжүүлэх, шинжлэх ухаан технологийн энэ ХАА-д гарч байгаа ололт амжилтыг нэвтрүүлэх, маш их олон асуудлууд байгаа юм. Тэгээд дотор нь нэг ийм юм л яваад байгаа юм л даа. Тэгээд энэ тэрийгээ засаж өөрчлөх боломж байгаа юу? Яг үүгээрээ ингээд явах юм уу? Яг ингэх юм бол дотно талыг нь энэ нэг бол би бол зөвшөөрмөөр л байна. Зээл бол сайн зээл байна. Энд хариулт өгөөч.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? 2 номер хариулъя. Маш тодорхой асуулт асуулаа шүү, тодорхой хариулаарай. Нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд, тэгээд хариулъя протоколд үлдэнэ.

Б.Одонтуяа: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Одонтуяа. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд таны хэлсэнчлэн үр дүн ер нь 4 үр дүнтэй хэрэгжих юм байгаа юм. Аймаг, сумын төвийн аймаг, сумын төвийг хөгжүүлэх чиглэлээр голчлон дэд бүтцийн ажлууд хийгдэнэ. Үүн дээр бол 395,7 сая долларын зээл болон буцалтгүй тусламжийн эх үүсвэр ашиглагдахаар байгаа.

Таны сая дурдсанчлан үр дүн 4-д бол чадавхыг бэхжүүлэх бодлогын шинэчлэлийг хийх чиглэлээр мөн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээр байгаа, ажлууд хийгдэхээр байгаа. Тэгэхээр зөвлөх үйлчилгээ ба сургалтын хэсэг маань өөрөө АХБ-аас олгох 3 сая долларын буцалтгүй тусламжийн хөрөнгийг бид нар зээлийн хэлэлцээрийн хүрээнд аль болохоор энэ зөвлөх үйлчилгээ сургалт гэх мэтчилэн энэ soft companion руу чиглүүлэх чиглэлээр бол Европын хөрөнгө оруулалтын банк, АХБ, Европ, Уур амьсгалын ногоон сангууддаа бас энэ талаар нэлээн хэлэлцээр хийсэн байгаа.

Мөн зээлийн үр дүн 3 буюу санхүүжилтээр хэрэгжүүлэх санхүүгийн зээл олгох, дамжуулан зээлдүүлэх, зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх гэх мэтчилнээр бас ажлуудад төсөвт өртгийн маань 117 орчим сая доллар нь зарцуулагдана. Энэ дээр бол зээлийн эрсдэлийн батлан даалт нь өөрөө хөдөө орон нутаг дахь барьцаа хөрөнгийн чадваргүй жижиг, дунд үйлдвэрлэгчдэд Зээлийн батлан даалтын сан хэлбэрээр зарцуулалт нь бас ашиглагдах юм. Ерөнхийдөө бол бид нар банк 3 банк бол хөрөнгө оруулагчаар ажиллаж байгаа. Европын хөрөнгө оруулалтын банк нь өөрөө олгох 130 сая доллароо аль болохоор дэд бүтцийн ажил руугаа санхүүжүүлэхээр ер нь бол бид нар дизайнаа хийсэн байгаа.

Нөгөө талаасаа Уур амьсгалын ногоон сангийн зүгээс бол аль болохоор уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг төсөл хөтөлбөрүүдэд санхүүжүүлэх зээл олгох чиглэлээр буцалтгүй тусламжаа хандуулах зэргээр ер нь бол банкнуудаас олгох бас хөрөнгө оруулалтын шаардлагууд нь бас янз бүр бол байгаа.

Б.Энх-Амгалан: Баттөмөр гишүүн тодруулъя. Нэмэлт хариулт байгаа юм уу? Хөдөө аж ахуйн яам, 3 номер Болорчулуун дарга хариулъя. Нэмээд.

Ц.Болорчулуун: Баттөмөр гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэр энэ АХБ-аас авч байгаа энэ зээлийн 1 дүгээр үе шат буюу 270 сая доллар ам.долларыг нь 1 дүгээр үе шатад зарцуулахаар байгаа. Үүнээс бол яг энэ хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөн түүнийг хэрэгжүүлэх 36 дугаар тогтоол дээр бол 128 сая доллар нь яг ХАА-н энэ салбар дээр, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд тавигдаж байгаа.

Үүнээс бол 27 орчим сая доллар нь бол буцалтгүй тусламж гэж тооцоолсон байгаа. Тэгэхээр энэ мал эмнэлгийн ажилчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ авагдана гэдгийг сая Одонтуяа даргын хэлсэнчлэн ер нь бол буцалтгүй тусламжийн хэсгээрээ санхүүжүүлээд ингээд явах ийм бололцоотой гэж тооцоолсон байгаа урьдчилсан байдлаар.

Б.Энх-Амгалан: Баттөмөр гишүүн нэмж тодруулъя.

Б.Баттөмөр: Буцалтгүй тусламжаар ч бай, зээлээр ч бай сургалтыг нэг их гаднаас хүн авч ирэх сургаад байх хэрэг байхгүй Болорчулуун. Монголын ХАА-н салбар бол маш их олон эрдэмтэдтэй. Харамсалтай нь Монголын төр энэ эрдэмтдийнхээ үгийг сонсохгүй байгаа, ашиглахгүй байгаа.

Энэ 735 сая долларыг зөв зарцуулах юм бол Монголын ХАА-г тэр чигт нь дээш нь өргөөд явчих ийм боломжтой. Тэгээд л нэг янз янзын юмнууд нэг сургалт хийнэ, тэгээд цахилгаан татна, авто зам хийнэ, бизнес төлөвлөгөө хийнэ, бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөө хийнэ ч гэх шиг одоо нэг ийм зүйлүүдэд зараад байх юм бол тэгээд нөгөө зээлийг зөв зүйлд зарцуулна гэдэг тэр чиг шугамтайгаа бол зөрчилдөж байгаа юм. Жавхлан сайдаа. Энэ дээр анхаарна уу. Энэ бол болохгүй.

Б.Энх-Амгалан: Ганбат гишүүн асуултаа асууя. Баттөмөр гишүүн санал хэлчихлээ.

Д.Ганбат: Өрийн хавханд орж байгаа, өрийн хавханд орох магадлал өндөртэй улс орны тоонд 4, 5 улс байдаг юм, тэрний нэг нь манай Монгол Улс л даа. Би тэгээд байгаа юм биш, энэ гаднынхан л тэгээд байгаа шүү дээ. Тэр нь ч үнэн юм шиг байгаа юм. 745 сая доллар бол их мөнгө, маш их мөнгө. Яг авч байгаа нөхцөл, яг ярьж байгаа зүйл бол их л сайхан сонсогдож л байна л даа. Тэгээд энэний ар талд юу байна вэ? Наад мөнгө төгрөгөө зарцуулаад ингээд яг хөрсөн дээрээ бугаад ирэхээр яг ямар юм болох юм бэ гэж би тодруулмаар байна.

Тухайлбал би Баянхонгор аймгаараа л жишээ авъя л даа. Иргэд маань их ядуу байна, ард түмэн бол ядуу байна. Наад мөнгө төгрөг чинь бол маш их хэрэгтэй байна. Хэрэв яг ярьж байгаа шигээ зөв оновчтой ингээд зарцуулах юм бол. Тэгээд энэ дээрээ яаж хяналт тавьдаг юм бэ? Бас л нөгөө өр нэмсэн, өрийн хавханд улам орох ийм ажил болгочихмооргүй байх юм. Өмнө нь дандаа л тийм байдаг байлаа. Тэглээ гээд ямар авахгүй байлтай биш, авах хэрэгтэй. Энэ хяналт шалгалтаа сайжруул.

Тухайлбал ХАА-н кластер, ХАА-н дэд кластер гээд төслийг би Баянхонгор аймагт бол санаачилж байгаа. Мэдээж хэрэг хэрэгжүүлэхийг нь тэр орон нутгийн байгууллагууд, энэ Хөдөө аж ахуйн яам, Сангийн яам хяналтаа тавиад явах ёстой л доо. Одоо 2 жил болж байна. Тэнд ялдаг нэг хэдхэн л компани бий тендерт, байдаг юм байна. Би мэддэггүй, анзаардаггүй байсан. Яг ингээд үзээд хараад ирэхээр. Тэгээд зарим бичиг баримтууд энэ тэрээ Сангийн яам руу явуулсан байгаа. Тэр шалгардаг компаниуд нь зүгээр тэр хово машины байх ёстой гээд хүнд машин техникийн даацтай ийм тендерт нь байх ёстой гээд заасан юмыг л зүгээр л нэг хово машин дээр, өөрийнхөө приус машины нэг

дугаарыг ингээд л хадаад л тэр тендер шалгарчхаж байна шүү дээ. Тэгээд нөгөө компаниуд нь санал гомдол гаргасан л юм билээ. Бүүр эрүүгийн шахуу хэрэг болж байгаа байхгүй юу. Хуурамч бичиг баримт бүрдүүлээд. Ийм зүйл явж байна.

Наад төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээрээ тэр ногоон хөгжил, тэр хүнсний бэлчээрийн доройтол энэ бүх юмтай бол тэмцэх юм байна л даа. Энэ бол яг ус, агаар шиг хэрэгтэй зүйл. Манай Баянхонгор аймагт яаж хэрэгжих юм бэ, яаж төлөвлөсөн юм бэ? Мэдээж хэрэг зээл авахаа авч байгаа үедээ бол төлөвлөчихсөн л байгаа байх л даа. Тэнд нь тэдэн төгрөг, энд нь ингэж ажиллана энэ тэр гээд. Тийм төлөвлөсөн юм байгаа юу, байхгүй юу? Тэр сургалт, судалгаа тэр энд тэндхийн гадна, дотнын хүмүүс гээд, зөвлөх үйлчилгээ гэдгээрээ маш их мөнгийг бол энэ дундаас нь бол үр дүн багатай ингэж авдаг л даа. Гэхдээ би ямар сургалт, судалгаа, зөвлөх тэр заах энэ тэр нь хэрэггүй гэлтэй биш. Тэр бол хэрэгтэй. Ялангуяа гадна, дотнын хүмүүсийг үр дүнтэй бараг хөдөө орон нутагт нь очиж ажиллуулаад, заалгаад ингээд явах нь үр дүнтэй. Тэрнээс биш гаднын хэдэн хүмүүс энэ Улаанбаатар хотод ирээд л үнэтэй зочид буудалд байж байгаад л ингээд буцаад явчихвал ямар ч хэрэг байхгүй. Эсвэл энэ Хөдөө аж ахуйн яам, Сангийн яамны тэр арын дарга нарын хэдэн бас нэг компаниуд энд оролцсон нэр зүүгээд л ийм ажил байж болохгүй.

Ер нь та нараас яг Баянхонгор аймагт, тухайн хөдөө орон нутагт, суман дээр, малчид дээр очиж ажиллах хэрэгтэй. Ерөөсөө очдоггүй шүү. Яах вэ энэ Хөдөө аж ахуйн яаманд бол бас энэ Болорчулуун дарга энэ тэр гээд бас ганц нэг сэтгэлтэй хүн байдаг юм шиг байгаа юм хараад байхад. Гэхдээ бас хангалтгүй ажиллаад байгаа шүү. Тэр ингэний сүүний.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ?
1 номерын микрофон.

Д.Эрдэнэбаяр: Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр. Ганбат гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам АХБ, Жайка ОУБ хамтраад энэ төслийг хэрэгжүүлэх байршилууд дээр бол нэлээн нарийн судалгаанууд хийгдсэн. Тийм учраас энэ төслийн мөнгөөр ахиж бүсчилсэн хөгжлийн юм уу, аймгийн хэмжээний судалгаанд бол зарцуулахгүй гэж төлөвлөж байгаа. Өөрөөр хэлбэл энэ судалгааны ажлыг бодит ажил хэрэг болгох тал дээр бол шууд төслөө хэрэгжүүлж явна гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Баянхонгор аймгийн хувьд бол энэ тооцоон дээр хөгжлийн ирээдүй сайтай, потенциал сайтай, хамгийн гол нь үйлдвэр үйлчилгээ хөгжих сайтай 2 сумыг бол энэ төсөлд оруулсан. Энэ дээр гол хийгдэх ажил нь бол ТЭЗҮ-ийг хийх ёстой. Яагаад гэхээр Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн дагуу бол зураг, төсөв ТЭЗҮ-тэй байж энэ хөрөнгийг бол зарцуулах шаардлага тавигдаж байгаа. Тэр утгаараа бол сургалт гэж бичигдээд байгаа юм шиг уншигдаж байгаа байх. Тэгэхдээ яг энэний цаана бол хэрэгжүүлэх ТЭЗҮ-ийг хийхээр байгаа.

ОУБ-ын туршилага болон дотоодод ААН-ээс тавьж байгаа гол хүсэлт нь бол дэд бүтцийн асуудал дээр төрөөс дэмжиж өгөөч. Өөрөөр хэлбэл аймаг, сумд байгаа үйлдвэр, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан бүс нутаг руу хувийн хэвилийг дэмжих журмаар дэд бүтцийг татаж өгөөч гэсэн хүсэлт байгаа. Энэ дагуу бол үйлдвэрийг дэмжих шаардлагаар дэд бүтцийг татна гэж ингэж орсон.

Дээр нь олгогдох зээл бол цэвэр арилжааны банкаар дамжиж явна. Өөрөөр хэлбэл төрийн ямар нэгэн оролцоо байхгүйгээр, арилжааны банк бол тодорхой энэ 2 сум дээр хийгдэх бүтээн байгуулалтыг шаардлагаа хангаж байгаа нь аваад хийнэ гэсэн ийм зохион

байгуулалтаар бол төслийн дизайн нь гарсан байгаа. Тэгэхээрээ бол арилжааны банк маань илүү энэ банкбел байна уу, үгүй юу гэдэг дээр өөрөө хувийн хэвшил хувийн хэвшилтэйгээ харьцаад явна. Монгол Улсын аль ч иргэн авч болно. Тэгэхдээ яг энэ заагдсан сумууд дээр Засгийн газраас дэвшүүлж байгаа хүнсээр дотоодын хэрэгцээгээ 100 хувь хангах энэ зорилго руу чиглүүлнэ.

Мөн орон нутагт иргэд ААН салбараа нээх энэ компани ажил явж байгаа. Энэний хүрээнд орон нутаг салбараа нээх гэж байгаа хүнс, хөнгөн үйлдвэрийн чиглэлийн ААН бол энэ зээлийг аваад, тусламжийг аваад энэ ТЭЗҮ-ийг хамтарч боловсруулаад ингээд үйлдвэр үйлчилгээний чиглэл рүү зарцуулахаар энэ төслийн бэлтгэл ажил хангагдсан байгаа.

Б.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн, тодруулах юм уу тийм ээ? Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Тухайлбал Баянхонгор аймагт хэчнээн хэмжээний мөнгө төгрөг тавигдах юм бэ энэ зээлээс чинь? Тэр 2 сум шалгарсан гэж байна, ямар шалгуураар, яаж шалгарсан юм, ямар сумууд байгаа юм бэ? Тэгээд арилжааны банкаар дамжихаар дамжих нь зөв л байх л даа. Мэдээж хэрэг бас эзэнтэй ийм, ийм байх нь зөв байх. Гэхдээ юу байх. Тэр хүү нь яаж өсөх юм бэ? Наадах чинь бол орж ирж байгаа юм нь хүү багатай ингээд явсаар байгаад нөгөө бүр жирийн зээл шиг дийлдэшгүй хүүтэй нэг ийм л юм болчих вий. Тэрэн дээр бас тодруулах хүсэлтэй байна.

Нөгөө талаар бол энэ аймгууд бас сүүлийн үед бол нэлээн хүн ам нь ихсэж байгаа, гайгүй ч болж байгаа. Тэр аймагт байгаа хүмүүсийнхээ хүнс тэжээлийг хангах, тэгэхийн тулд тэр аймагт байгаа ойролцоо сумууд тухайлбал тэр төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа Баян-Овоо байна, Өлзийт гэх сумууд байна. Энэ дээр.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Ганбат гишүүн санал хэлчихлээ. Тэр Баянхонгор аймагт юутай холбоотой асуудал байна. Ямар 2 сум байгаа юм гэдэг асуудлыг нь хэлээдэх. 1 номерын микрофон. Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбаяр дарга хариулъя.

Д.Эрдэнэбаяр: Бид нар тооцооллоо гаргахдаа бол ШУА-тай хамтарч бас нэлээн нарийн тооцоонууд хийсэн. 119 шалгуур үзүүлэлтээр орон зайн татагдах гэж байгаа эрчим хүч, зам, боомт, логистик төв, мөн транзит тээвэр гэх мэт олон холболтын энэ байришилтай ойрхон байна уу, үгүй юу гэдэг судалгааг хийсэн. Мөн хүн амын шилжилт хөдөлгөөний тохиромжтой судалгаануудыг хийсэн. Нийгэм, эдийн засаг, байгалийн дагалдах түүхий эд, малын тоо толгой зэрэг үзүүлэлтүүдийг харгалзаж үзээд ойрын 100-аас 150км-т байгаа түүхий эдийг энэ сумууд дээр төвлөрүүлнэ гэдэг ийм тооцооллоор бол ШУА-тай хамтарч хийсэн судалгааны үр дүнд бид нар энэ 17 аймгийн 52 сумыг бол тооцож гаргасан байгаа. Яг Баянхонгор аймаг дээр бол Баянхонгор, Бууцагаан гэсэн 2 сум орсон. Нөгөө талаасаа энэ хөтөлбөр маань хүнсний хангамж гэдэг рүү нэлээн чиглэж байгаа учраас зарим хангайн бүсийн хүнс үйлдвэрлэж байгаа компаниуд илүү.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн асуулт асууя.

Н.Энхболд: Төв аймгийн 4 сум байгаа. Зуунмод, Баянчандмань, Лүн, Угтаал гээд. Яг юу хийх юм түүн дээр? Их олон академи, академитай хамтарч аваачиж нарийн шинжилж үзсэн гэж байна. Бүгдээрээ дэд бүтэц харьцангуй гайгүй, замаар холбогдохсон. Угтаалыг бол ингээд удахгүй холбочихно. Лүн гэхэд маш том махны үйлдвэр хувийн компани бариад ашиглалтад үндсэндээ орж байна. Тэгэхээр яг энэ сумнуудад юу хийхээр бодсон бэ 1-д.

2 дугаарт аймаг орон нутагтай нь өөрсдөө ярьсан уу эсхүл зөвхөн

академитай яриад ингээд хийчихсэн үү? Нэг ийм асуудал асуулт байна.

Энэ та нар энэ гэрээ юмаа орчуулахдаа бас нэг хүнд жосоохон ойлгомжтой бичиж орчуулж утгаар нь орчуулж байхгүй бол зүгээр нэг үгнүүдийг нь орчуулаад тавьчихаар шийдвэр гаргах гэж байгаа хүмүүс ч гэсэн ойлгомжгүй байна шүү дээ. Жишээ нь нүүрстөрөгч багатай уур амьсгалд тэсвэртэй мал гэж юуг хэлж байгаа юм бэ? Уур амьсгалд тэсвэртэйг нь ойлгож болж байна. Нүүрстөрөгч багатай мал гэж. Энэ хувилбар нэг гэдгийн чинь 5 дээр байна. Тэгээд би гайхаад харлаа л даа. Ард хойд талын нөгөө англиар нь. Малын гаралтай бүтээгдэхүүний тухай л ярьж байгаа бололтой юм. Тэгэхээр энэ дээр болохоор нүүрстөрөгч багатай малыг нийлүүлэлт гэсэн маягаар орчуулсан байх юм. Үзсэн харсан юм байдаг юм уу? Хэн орчуулдаг юм бэ? Орчуулгын гол нь энэ чинь, одоо үзээд танилцаад, шийдвэр гаргах гэж байгаа улсуудад ойлголтой юмнууд байх хэрэгтэй шүү дээ.

Тэгэхээр тэр түрүүчийн яг тэр 4 сум дээр юу хийх гэж байгаа юм бэ, тэгээд нүүрстөрөгч багатай мал гэж юу хэлдэг юм бэ тэрийг нэг. Дараа нь би санал дээрээ үг хэлнэ. Тийм.

Б.Энх-Амгалан: *Эдийн засгийн хөгжлийн яам 1 номер, Эрдэнэбаяр дарга хариулъя.*

Д.Эрдэнэбаяр: *Төв аймаг дээр 4 сум орсон байгаа. Энийг бол зөвхөн эрдэмтэн судлаач нар гаргаагүй. Аймаг дээр энэ тухайн аймаг болгон дээр очиж 2 удаагийн хэлэлцүүлгийг нийт ААН эрхлэгч болон аймгийн удирдлагуудтай хамтарч 2 удаагийн хэлэлцүүлэг хийсэн. Дараа нь мөн Эдийн засаг, хөгжлийн яаман дээр бүх Засаг дарга нар болон Засаг даргын орлогч нар оролцож хэлэлцүүлэг хийж, энэ нэрийг бол саналыг бас авч тодорхойлсон байгаа.*

Яг хийгдэх ажил нь бол сум болгон дээр ТЭЗҮ-ийг хийнэ. Энэ ТЭЗҮ-ийн

хүрээнд тухайн сумын нөөц, харьцангуй давуу тал, хувийн хэвшлийн хүсэл сонирхол юу байна гэдгийг бол тооцож гаргаад энэ хэмжээнд нь таарсан хүчин чадал, төсөвт өртөгтэй үйлдвэр, үйлчилгээ, худалдаа, тээвэр логистикийн цогцолборыг иж бүрнээр нь хийхээр тусгасан байгаа. Яг үйлдвэр, үйлчилгээ тээвэр логистик дээр бол төр оролцохгүй. Энэ бол цэвэр хувийн хэвшлийн өөрийнх нь менежментээр явна. Төрийн гол дэмжлэг бол эдгээр сумууд руу үйлдвэр, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байриил руу бол дулаан, цахилгаан, цэвэр ус, цэвэрлэх байгууламжийг бол шийдэж өгнө. Энэний өөрийнх нь зураг төсвийн хүрээнд төсөвт өртөг нь шийдэгдэнэ. Эндээс бол урьдчилаад тэд эд гэж бол тооцоо гаргаагүй. Яагаад гэхээр энэ нь байриил болгоныхоо холболтын зураг болон ТЭЗҮ, хүчин чадал, нөөц энэ зэргээс хамаараад бүх сум бол өөр гарч байгаа. Зарим сум бол цэвэр 100 хувь хүнсний ногоон дээр суурилж байгаа бол зарим нь мах, сүү гэх мэт олон төрлийн бүтээгдэхүүн орж байгаа. Тэгээд энэ бол ТЭЗҮ-ээрээ төсөв нь гарна. Хувийн хэвшлийн саналыг бол авч хэрэгжүүлнэ.

Өмнөх туршлагаар бол төр үйлдвэр, технологийн паркийн ТЭЗҮ болон удирдлага руу илүү ороод байсан бол энэ төсөл цэвэр хувийн хэвшлийн өөрийнх нь санал дээр явахаар ингэж тооцож байгаа. Өөрөөр хэлбэл төр ямар нэгэн байдлаар энэ үйлдвэр, үйлчилгээний цогцолбор луу хувь эзэмшиж орохгүй гэдэг байдлаар явж байгаа. Орчуулгын талаар бол нэмэлт тайлбарыг Сангийн яамнаас хийх байх. Ер нь гол санаа нь бол бэлчээрийн даацтай зохицсон хэмжээний мал сүргийн бэлчээрийн даацтай тохирсон ийм байдлаар тодорхойлох нь зүйтэй. Тэгээд бусдыг нь бол эдийн засгийн эргэлтэд урамшууллын маягаар оруулж, малчдынхаа ажилгүйдэл, ядуурлыг шийднэ гэсэн үндсэн санаа бол ийм байгаа юм.

Б.Энх-Амгалан: *Үндсэн санаагаа зөв ойлгогдохоор бич гэж байна. Анхаарч*

аваарай Эрдэнэбаяр даргаа. 2 номер орчуулгын асуудлыг Сангийн яам хариулаадах. Одонтуяа.

Б.Одонтуяа: Орчуулгын асуудлаар тодруулга өгье. Ерөнхийдөө энэ аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд хүрээнд бол нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр МАА-н салбарт бол бодлогын арга хэмжээг ингэж тусгасан байгаа юм. Тэгэхээр таны хэлсэн бол нүүрстөрөгчийн ялгарал багатай МАА гэсэн агуулгаар бол уншигдана.

Нөгөө талаасаа бас уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох МАА гэсэн агуулгаар 2 төрлийн концепт бол явагдаж байгаа, яригдаж байгаа энд. МАА.

Б.Энх-Амгалан: Нүүрстөрөгч бага ялгаруулдаг мал гэж ямар юм байдаг юм бэ л гэж асуугаад байна шүү дээ.

Б.Одонтуяа: Тэгэхээр энэ нь болохоор цаашидаа ер нь бол бид нар Парисын хэлэлцээр гээд дэлхийн хэмжээнд нөгөө нүүрс төрөгчийн Монгол Улсын хүрээнд нүүрс төрөгчийн ялгаруулалтыг бууруулах зарим зорилгуудыг тавьсан байдаг. Хамгийн том салбар бол өөрөө эрчим хүчний салбар. 2 дахь салбарыг бол МАА гэж тодорхойлсон байдаг. МАА-н хүрээнд болбол ямар асуудал гардаг вэ гэхээр малын өөрөө амьсгал бас мөн ялгасдаг гэдэг зүйлүүд нь өөрөө нүүрстөрөгчийг их хэмжээтэй.../үг тасрав/

Б.Энх-Амгалан: Миний дүү чи худлаа хариулаад байна. Тэгээд 3 номер хэн Болорчулуун дарга нь хариулаадхаач. Юу гэсэн үг юм бэ яг наадах чинь?

Ц.Болорчулуун: Яах вэ МАА гээд шууд биччихсэн учраас бас ойлгомжгүй харагдаад байгаа байх. Ер нь бол МАА-н салбар гэдгээрээ л явж байгаа. Тэгээд энэ дээр бол орчуулга дээрээ бас анхаараад, зөв найруулга хийх нь зүйтэй байх л гэж бодож байна.

Б.Энх-Амгалан: Ойлголоо. Нэмэлт тодруулах юм уу та? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Наранбаатар гишүүн байгаа, уучлаарай. Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Энэ аливаа төсөл, хөтөлбөр, зээл тусламжид ерөөсөө Өмнөговь аймаг л дандаа хаягдаж байх юм. Тэгээд эндээс харж байхад 17 аймаг дотор бас л Өмнөговь аймаг байхгүй л байх юм. Тэгээд яаж сонгож аймгуудаа ингээд байгаа юм бэ? Ногоон болгох, бэлчээрийг нь доройтол, энэ ус хуримтлуулахад хамгийн шаардлагатай байгаа аймаг уг нь Өмнөговь аймаг л байгаа шүү дээ. Хамгийн хэрэгцээтэй зүйл бол усны асуудал байж байна. Энэ зуны зуншлага гантай малчид нь отор нүүдэлтэй, усгүй бороогүй хүнд хэцүү л байгаа. Томоохон төслүүд бас усны гачаалтай ингээд л байж л байгаа.

Тэгээд таширамд энэ Эдийн засгийн хөгжлийн яамнаас тэр Орхон Онги төсөл ямар хэмжээнд явж байгаа вэ гэдгийг бас асуучихъя гэж бодоод байгаа юм.

Тэгээд энэ 2-т нь бол энэ аймгуудаа яаж сонгоод байгаа юм бэ, яагаад Өмнөговь аймгийг хасчхаад байгаа юм бэ? Авах юмаа бол сайн авч байгаа шүү дээ, энэ чинь улсын төсвийг Өмнөговь аймаг бүрдүүлж байгаа юм. Тэгээд өгөх юм гээд зөрүүлээд энэ нэг төсөл хөтөлбөрөөсөө өгчих юм ерөөсөө байхгүй, дандаа хасаад хаячихдаг. Ямар шалтгаанаар, яагаад ингээд Өмнөговь аймаг бүх л төсөл, хөтөлбөр янз бүрийн юмнуудаас хасагдаад байдаг юм бэ?

Бид сая улсын төсвийн тодотгол хийсэн. Төсөв 1,1 их наядаар давж биелсэн төсвийн орлого. Он дуусахад бас энэ хэмжээнд гэвэл бараг 2 их наяд төгрөгөөр төсвийн орлого маань давж биелэх гэж байна шүү дээ. Энэ өнгөрсөн жил баталснаасаа. Тэгээд энэ төсөв мөнгө чинь хаанаас ороод байгаа юм Өмнөговьос л орж байгаа шүү дээ.

Нүүрсний экспортоос л энэ төсвийн орлого чинь биелж байгаа. Тэгээд төсвийн ихэнхийг бүрдүүлж байна. Өмнөговь аймаг өөрөө энэ жил 465 тэрбум төгрөг өөрийнхөө орлогоос улсын төсөвт шилжүүлж өгнө, татаас хэлбэрээр өгнө. Ингээд энэ цалин, тэтгэвэр сая нэмлээ, хүүхдийн мөнгө 100 хувь бүх хүүхдэдээ өгөх боллоо гээд л ингээд л шийдвэрүүд гаргалаа шүү дээ. Тэгээд энэ мөнгө хаанаас гарч байгаа юм Өмнөговь аймгаас л гарч байгаа. Тэгээд эргүүлээд Өмнөговь аймагт өгч байгаа юм ерөөсөө байхгүй. Ингээд л харахаар хүснэгт олон аймгууд ярайтал ингээд л байж байгаа. Тэгээд л Өмнөговьд байхгүй.

Тэгээд хийх ажлууд нь энэ бэлчээрийн доройтлыг сэргээх, энэ борооны хурын усыг хуримтлуулах барих гээд л ийм ажлууд, ядуурлыг бууруулах гээд. Тэгээд энэ хийхэд хамгийн шаардлагатай байгаа аймаг чинь л Өмнөговь. Газрын гүний усыг нь ховх сороод уул уурхайдаа хэрэглээд, энэ чинь малчид нь малаа усалж чадахгүй болчихсон, худгууд нь ширгэчихлээ л дээ. Тэгээд бороо хур орохоо байгаад, жилээс жилд ган гачиг нүүрлээд, малчид нь ойр хавийн аймгууд руу нүүгээд ингээд алга болсон ийм байдалтай л хүнд л байна. Тэгэхээр энэ яагаад ингээд ялгаварлан гадуурхаж Өмнөговь аймгийг бүх энэ төсөл хөтөлбөрөөсөө хасаад ингээд ялгаад байдаг юм гэдгийг асуучихъя. Тодорхой хариулаадхаач, тэгээд дараа нь тодруулъя.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? Сангийн сайд Жавхлан хариулъя. Сангийн сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Өмнөговь аймагт газар зүйн байрлалаараа манай үндсэн томоохон ашиглалтад эргэлтэд орж байгаа ордууд байдаг нь үнэн. Гэхдээ энэ Монголын ард түмний баялаг шүү дээ. Үндсэн хуулиараа маш ойлгомжтой байгаа. Зөвхөн Өмнөговьчуудад заяагдсан эд биш, би маш тодорхой хэлье. Энэ бол Монголын ард түмэнд газрын хэвлий дэх

энэ байгалийн баялгийн энэ нөөц бүх ард түмнийхээ гэдгийг бид нар Үндсэн хуулиараа 6.2 дээр маш тодорхой заагаад өгчихсөн байгаа байх. Тийм учраас энийг одоо, энэ манай аймгийнх, тэр аймгийнх биш, тэр аймаг руу одоо ингээж харин ярих нь хэр зохистой юм бол доо.

Бид чинь нэгдмэл улсын төсөвтэй шүү дээ. АНУ шиг тийм нэгдсэн улсын төсөвтэй биш. Өмнөговь аймгаас орж ирсэн төсвийн орлого түүгээр Дорнод аймагт, Баян-Өлгий аймагт төрийн үйлчилгээг санхүүжүүлдэг, цэцэрлэг, сургууль барьж өгдөг, эмч, багш нарынхаа цалинг нь мөн тэндээс тийш нь санхүүжүүлж явдаг бид нар ийм л төсөвтэй улс. Тийм тэгэхээр тэрийг тэгж болохгүй байх тэгж ярьж.

Энэ төсөл анх манай Засгийн газар хүлээж аваад, энэ төслийг үзэхэд гуравхан аймаг байсан шүү. Ерөөсөө 3 аймагт л зориулагдсан ийм төсөл байсан. Тэрийг харин одоо 17 аймаг болгочихсон байгаа. 17 аймаг 50 хэдэн сум билээ, 52 сум суурин газруудыг хамрагдсан ийм төсөл болгож нэлээн хүртээмжтэй байдлаар ингээж шинээр дизайн хийсэн байгаа. Тэр аймгууд дээр ямар шалгуураар, үндсэн шалгуурууд нь яаж явсан тийм, Өмнөговь аймаг яг 17 аймагт яагаад багтаагүй, ер нь ганц Өмнөговь биш, бусад өөр багтаагүй аймгууд нь ямар шалгуур дугаараар багтаагүй. Тэр нь үндсэн шалгуур нь бол ороогүй аймгуудын хувьд энд хийгдэж байгаа дэд бүтцүүд нь харьцангуй бусад аймгуудаас илүү урагшаа явчихсан байгаа, харьцангуй хийгдчихсэн байгаа ажлууд байгаа учраас гэсэн ийм сонголт байгаа гэж. Тэгээд тэр талаараа Эдийн засгийн хөгжлийн яамнаас дэлгэрэнгүй ярьчих.

Б.Энх-Амгалан: Нэмээд Эдийн засгийн хөгжлийн яам Эрдэнэбаяр дарга хариулъя. 1 номерын микрофон.

Д.Эрдэнэбаяр: Өмнөговь аймгийн хувьд бол 4 сум бол энэ бүс нутгийн кластер болох хамгийн тохиромжтой сумаар тооцогдож гарч ирсэн. Үүнд бол

Гурван тэс, аймгийн төв, Цогтцэций, Ханбогд гээд 4 сум байгаа. Энэ 4 сумыг аваад үзэхээр энэ Оюу толготой болон энэ Оюу хөгжлийн сантай явж байгаа төслүүдийн хүрээнд авто зам болон инженерийн дэд бүтэц мөн ерөнхий төлөвлөгөө ТЭЗҮ-нүүд бол маш сайн хийгдчихсэн ийм байдалтай байгаа. Тийм учраас энэ бид нарын хийгдэх гэж байгаа ажил бол давхардаж байгаа учраас энэ тооцооноос 1 дүгээрт бол хасагдаж байгаа.

Нөгөө талдаа бол хамгийн гол нь энэ хүнсний хангамж, аюулгүй байдал дээр энэ хөтөлбөр бол суурилж байгаа гэдэг агуулгаар хангайн бүсийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх түшиц газар буюу компаниуд суурьшичихсан энэ бүс нутаг руу бол түлхүү анхаарч энэ төслийн дизайн хийгдсэн. Нийт шалгуур нь бол 119-ийн шалгуураар авсан. Тэгээд энэ шалгуурын хүрээнд бол саяын 4 сум гарч ирээд хийгдэх ажил нь бол маш сайн улсын бараг тэргүүний шахуу хэмжээнд дэд бүтцүүд, холболтын авто замууд, бусад эх үүсвэрээр явж байгаа учраас хасагдсан байгаа. Мэдээж бусад сумтай хийх энэ сургалт болон чадавхжуулах арга хэмжээг бол бүх аймаг сумын түвшинд хамруулаад хийхээр төлөвлөсөн байгаа.

Б.Энх-Амгалан: Наранбаатар гишүүн тодруулъя. Наранбаатар гишүүний микрофоныг өгье. Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Тэр ноднин төсөв хэлэлцэх Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд суусан Орхон Онги төслийг ТЭЗҮ боловсруулагдаад, одоо зураг төсөв гээд энэ жил хийгдэж байх ёстой. Тэгээд энэ ажил ямар хэмжээнд явж байгаа юм бэ? Тэгээд нэгдмэл улс гэдгийг бол бүгдээрээ л мэдэж байгаа. Тэгээд гол нь яагаад Өмнөговь аймгийг энэ төсөл, хөтөлбөр янз бүрийн юмнаас орхиод хасаад байгаа юм бэ л гэдгийг хэлж байгаа шүү. Бусдаар бол нэгдсэн 1 төсөвтэй ийм улсын гэдгийг мэдэж байгаа. Гол нь тэнд баялаг

байгаад, баялгийг гаргаад, ашиглаад гээд уул уурхайн үйл ажиллагаа яваад байгаа учраас тэр бүс нутаг цөлжөөд байна, ус нь багасаад байна, бэлчээр нутаггүй болоод байна гэдгийг л яриад байгаа юм. Бусдаар бол баялаг хэний тухай бол ерөөсөө би ярьсан юм байхгүй.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? Жавхлан сайд, Сангийн сайд Жавхлан микрофоныг нь өгье.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний тойргийн зовлон, тойргийн асуудлыг хүндэтгэж үзэж байна. Ингэж хэлэх нь юу нь буруу байх вэ. Гэхдээ Өмнөговь аймгийг онцлоод хасаад байна гэж юу байх вэ дээ. Тухайн төслийн шалгуурууд, зориулалт, тэгээд үр ашигтай юу, үгүй юү, давхцал байна уу үгүй юү гээд тэрнээс илүү шаардлагатай хүнд аймаг орон нутгууд ч зөндөө байгаа. Тэгээд сая энэ төслийн хувьд бол сая бас тодорхойлон хэллээ. Хэрвээ зүгээр өөр төслүүд дээр хамрагдах байсан боловч бүүр улайм цайм ингээд ялгаварлаад хасаад тэгчихсэн зүйл тодорхой зүйл байвал та бидэнд хандаарай. Бид нар эргэж харах зүйл боломжтой зүйл байвал үзье. Тэрнээс биш Өмнөговьчуудыг байгалийн баялагтай аймаг гэдгээрээ хохироод байна гэж юу байх вэ. Харин ч ер нь сүүлийн жилүүдийн бүхий л дэд бүтэц, энэ экспортын бүтээн байгуулалт ялангуяа хил боомтын хөрөнгө оруулалтууд бол бүгд л.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Орхон Онги төслийн асуудлаар хэн хариулах вэ? Эдийн засгийн яам хариулах уу? Ажлын шугамаар өгье. Тэгвэл ажлын шугамаар хэнд. Тэгвэл наад 1 номерын микрофон дээрээ хэлчих. Эрдэнэбаяр дарга.

Д.Эрдэнэбаяр: Орхон Онги төслийнхөө асуудлаар.

Д.Эрдэнэбаяр: Яг энэ асуудлыг бол холбогдох газрын даргатай нь ярьж, албан шугамаар хүргүүлье. Яагаад гэвэл энэ төслийн манайхтай холбоогүй учраас

надад бол бас тодорхой мэдээлэл яг одоо байхгүй байна. Бичгээр өгье.

Б.Энх-Амгалан: Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдэд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Дараа нь би үг хэлнэ. Нямаагийн Энхболд гишүүн үгээ хэлье.

Н.Энхболд: Товчхон үг хэлнэ. Энэ хөтөлбөрийн гэрээг ерөнхий хэлэлцээрийг дэмжинэ, дэмжиж байгаа. Онцгой үр ашигтай л байх хэрэгтэй байна. Тэгээд түрүүн бас зарим гишүүд ярьж байна лээ. Энэ нэг олон сургалт семинар, судалгаа энэ юмнуудыг аль болохоор бага хийгээд, Баттөмөр гишүүн бас яриад байсан, Ганбат яриад байсан. Бид нар өөрсдөө хийж чадах юмнуудаа энэ мөнгөөр аль болохоор өөрсдөө хийж, ядаж хамгийн наад зах нь Монголчуудаа Монгол эрдэмтдээ энд хамруулж, тэдэнд энэ бас үр ашгийн тодорхой хэмжээгээр очиж байх, тэд нарыгаа үнэлж байх энэ юмнуудыг их анхаарах хэрэгтэй.

Ер нь бол энэ олон улсын байгууллагуудын шугамаар хэрэгжүүлж байгаа зээлийн хэлэлцээр гэрээнүүдийн ард бол бүүр тийм бүхэл бүтэн багууд байдаг. Сүүрэг гэж би заримдаа нэрлэдэг юм. Бие биеийгээ энд тэндээс дуудаад л тэнд нэг тийм гэрээ яригдаж байна, энэ дээр хэдүүлээ ажиллана шүү гээд л очдог. Тэгээд л баахан сургалт, семинар, тэр хажууд хажуу талынхаар нь хийдэг юмнуудыг дундаас нь баахан юм цохиод явдаг. Сүүлийн үед зүгээр энэ орж ирж байгаа гэрээнүүдийг нь яг тэр хэсэгт зарцуулагддаг мөнгөнүүд нь багасаад байгаа. Энэ бас их сайн тал.

Тэгээд энэ дээр ч гэсэн та нар энэ Их Хурлаар орж батлагдана. Тэн дээр асууна. Байнгын хороон дээр яригдсан зүйлүүдээс жишээ нь тэр сургалт семинар, судалгаа энэ юмнуудад зарцуулах мөнгө чинь тодорхой хэмжээгээр буурсан уу, үгүй юү гэж асууна шүү. Хариулт авна. Тэгээд тэрний

хариулт тэр хариултаас дараа дараагийн энэ орж ирж байгаа гэрээ хэлэлцээрүүдэд бид нар яаж хандах вэ, Байнгын хороон дээр яригдаж байгаа юм чихнийх нь хажуугаар өнгөрөөд байна уу эсхүл бас энэ дээр анхаарал тавьж, гишүүдийн зүгээс гарч байгаа санал санаачилгуудыг тусгаж байна уу гэдгийг харах болно гэдгийг хэлчихье.

Би түрүүн тэр орчуулгатай холбоотой юман дээр хэлсэн юм. Тэгэхдээ энийг үнэхээр сайн хийж байх хэрэгтэй. Тийм мал гэж байхгүй шүү дээ. Тийм мал, малын гаралтай бүтээгдэхүүн ХАА-н агро бизнес гэвэл ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийх нь valuechain гэсэн үг байхгүй юу энэ чинь. Нэмүү өртгийнх нь тэр цуврал сүлжээ ямар байна гэсэн үг болохоос биш тийм хий багатай мал нийлүүлэх тухай асуудал энэ дээр үг, үсгээрээ байхгүй шүү. Би энэ та нарын ажлыг л бодож хэлж байгаа юм. Шийдвэр гаргах гэж байгаа хүмүүст ойлгомжтой, зөв ойлголт өгөхөөр хэмжээнд энэ юмнуудаа орчуулж хийж бай гэж.

Тэгээд сумдыг хөгжүүлнэ гээд ерөнхий биччихсэн байгаа юм. Гэтэл яг энэ дээрээ бичсэнээрээ болохоор яг тэр сонгож авсан сумууддаа хувийн хөрөнгө оруулалтыг бас тэнд хамт төвлөрүүлж байж тэрийг төв болгож байж, тэрийг тойруулсан бүсээ хөгжүүлнэ гэж байгаа болохоос биш яг тэр сумнуудыг хөгжүүлэх тухай энэ ойлголт энд байхгүй шүү. Тэгж ойлгуулж байж дэмжлэг авч байгаа гэж бодоорой. Тэгэхгүй бол зүгээр л одоо тэр нэг хүн амьдрах бололцоотой тэр сумнуудыг нь хөгжүүлнэ гэдэг тухай асуудал байхгүй. Тэнд нь хувийн хөрөнгө оруулалтыг энэ зээлээр авч байгаа мөнгө, улсаас гаргаж байгаа мөнгө, хувиас оруулж байгаа хөрөнгийг тэнд төвлөрүүлж байж бүтцээ тэнд нь бий болгож байгаад тэрийгээ тойруулаад тэр хавийнхаа бүсийг хөгжүүлнэ гэсэн ойлголт энэ хэлэлцээрийн цаана байгаа. Түүнээс төр зөвхөн тэр сумдыг хөгжүүлэх тухай асуудал байхгүй. Та нарын бичсэнээр бол тэр сумнуудыг

хөгжүүлнэ гээд л биччихсэн байна лээ. Ийм, ийм юмнууддаа анхаараач гэж байгаа юм.

Б.Энх-Амгалан: Ганбат гишүүн санал хэлье.

Д.Ганбат: Ингээд энэ зээлийн үр дүн ямар байх яах ийх гээд ингээд бас тодорхой хэмжээний ойлголттой болж байна. 8 сум, 8 аймаг 4 сумдаа авсан байна. 2 аймаг 3 сумдаа авч, бусад нь 5, 6 аймаг 2 сумд авсан байна. Ер нь бол гаднын зээл, тусламж хөтөлбөр улсын төсвийн хөрөнгө оруулалт талыг нь цавчаад л тал нь хөрсөн дээрээ буудаг. Тэр нь бол үр дүн муутай тийм л юм баригддаг л даа. Ийм л байгаа.

Би жишээ татаад л хэлье. Тухайлбал энэ Нисэх онгоцны буудал байна. Манай Чингис хааны нэрээр нэрлэгдсэн. 250 сая төгрөгийн өртгөөр босох ийм нисэх онгоцны буудал өнөөдөр 650 саяар боссон байгаа байхгүй юу. Тэгээд ямар их зай багатай ийм нисэх онгоцны буудал болсон бэ. Тийм их мөнгөөр. Тэгэхэд чинь бусад улс орнууд тэр Туркийн Станбул энэ тэрд чинь бараг энэнээс 5, 10 дахин том тийм хэмжээний hub бараг л 700, 800 сая доллароор л босож байгаа байхгүй юу. Ийм л үр дүнтэй байгаа. Тийм.

Яах вэ эрх биш нэг би аймаг дээрээ ХАА-н кадастр төсөл энэ тэр гээд яриад байдаг болохоор эрх биш манай 2 сумыг хамруулсан юм шиг байна та нар. Тэгээд яг энэ яг шаардлагатай аймаг сумнуудад энэ төсөл, хөтөлбөр чинь хэрэгжиж чадахгүй байна. Тэр бэлчээрийн доройтол явагдаад байгаа, ган гачигт автагдаад байгаа, зуд болоод байгаа, тэр уул уурхай үнэхээр хэтэртэл яваад байгаа, гүний ус нь доошилчихсон ийм аймгуудад бол хэрэгжихгүй л байна шүү дээ. Говийн, тал хээрийн энэ аймгуудад. Тэгэхээр та нарын тэр хийсэн судалгаа энэ бараг л эрдэм шинжилгээний ажил шахуу л юм ярилаа. Тэгээд зүгээр энэ дээрээс харахад л ингээд харагдаж байна шүү дээ.

Хөшөө болохоороо л тэр Хэнтий аймагт аваачаад л бариад байдаг, бас энийг болохоор л Хэнтий аймагт аваачаад л хийгээд байдаг. Тэгээд энэ чинь арай хэтэрлээ шүү дээ. Энэ чинь 21 аймагтай шүү дээ. Говийн, говийн аймаг яачхаад байгаа юм. Энэ Засгийн газрын хийж хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг хар. Одоо энэ ярьж байгаа юм нь ийм боловч тэр мянгат малчин шалгаруулна, сайн малчид гээд. Энэ чинь яг энэний эсрэг ажил байгаа байхгүй юу. Хамгийн тэр нүүрсхүчлийн бага хий бага ялгаруулдаг энэ мал бол мэдээж хэрэг энэ бэлчээрийн МАА. Энэ бол ойлгомжтой, байгальд ээлтэй ийм л МАА шүү дээ. Олон жил манай Монголын ард түмний амь амьдралыг аваад явж ирж байсан.

Ямааны асуудал бол хүндэрсэн. Энэ талаар бас ямар арга хэмжээ авах юм, яах юм ийх юм бэ, судалгаа шинжилгээ хийж байгаа, энэ талаар ярьж байгаа ийм зүйл алга байна шүү дээ. Зүгээр л энэ гадна, дотнын төсөл хөтөлбөр зээлийг бол өөрийнхөө сонгогдох сонгуулийн нэг хэрэгсэл болгож байна шүү дээ. Яг тийм газар дээр буусан Монголын ард түмэнд хэрэгтэй, үр дүнтэй ажил энэнээс 20, 30 хувь л гарах байх. 100 хувь гэж бодвол. Ийм л юмыг хэрэгжүүлж байна. Уул нь ингээд дэмжээд явмаар байдаг. Эрх биш манай 2 сумыг тусгасан учир, тусгасан учраас би дэмжиж л таарах байх даа. Тэрнээс биш наад үр дүн, энэ дээр тавьсан юмыг харахад бол бас арай хэтэрхий байна шүү нөхдөө. Та нарын ам, ажил бол маш их зөрөөтэй байна. Би яагаад ингээд яриад байна вэ гэхээр бас Монголын ард түмэн ойлгог, гэгээрэг, юм мэдэг гэж бодоод яриад байгаа юм. Товчхондоо ийм байна.

Б.Энх-Амгалан: Наранбаатар гишүүн санал хэлье. Наранбаатар гишүүний микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Энэ хөтөлбөр зээлийн зориулалт нь бол бүсчилсэн ногоон хөгжлийг л дэмжих зориулалттай байгаа. Газрын зураг дээр та бүхэн

хараарай. Хамгийн ногоон биш шав шар өнгөтэй байгаа нь л Өмнөговь байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тавьсан аймгууд чинь угаасаа ногоон байгаа, газрын зураг дээр ногоон байгаа аймгууд Архангай, Өвөрхангай гээд л хангай аймгууд. Тэгээд уг нь энэ зээлийн зориулалт чинь уг нь энэ цөлжөөд байгаа ногоон биш, шар түвшинд оччихоод байгаа энэ аймгууд руугаа л уг нь зориулагдаж явах ёстой юм шиг санагдах юм. Тэгэхээр тэртээ тэргүй ногоон байгаа, бэлчээр худаг ус, байгалийн гол нууртай ийм газрууд руу л түлхүү аймгууд тавигдчихаад, тэгээд хамгийн их цөлжиж байгаа газар байхгүй.

Уул уурхай мэдээж Монгол орныг тэжээж байгаа, төсөв бүрдүүлж байгаа ийм газар. Үүнийг чинь дагаад сөрөг нөлөөлөл маш их байна. Энэ уул уурхайг дагаад. Энэ чинь бас огт байгаль дэлхийд нөлөөлөлгүй эд биш байна. Энийг чинь дагаад бэлчээр байхгүй болж байна, худаг ус ширгээж байна. Жилээс жилд энэ малчдын, хүмүүсийн тэр орон нутгийнхны амьдрал ахуй доройтож байна. Тэгээд ийм зүйлүүд байгаад байгаа учраас энэ зээлийнхээ зориулалт, хөтөлбөрийнхөө зориулалтыг судалгааг хийхдээ яг нөгөө цээлээ олж л хийдэг баймаар байх юм. Хамгийн шаардлагатай газарт нь байхгүй, 1 ч сум нь байхгүй. Энэ зарим гишүүн хэлж байна шүү дээ. Манайхаас 2-хон сум байна бусад нь алга байна гээд л. Энэ чинь бүүр аймгаараа байхгүй, 1 ч сум байхгүй ийм аймаг байж байна шүү дээ.

Тэгээд хамгийн их энэ уул уурхайгаа дагаад энэ бэлчээр, усжуулалт, аялал жуулчлал хөгжүүлэх шаардлагатай, МАА, газар тариалангаа хөгжүүлэх ийм шаардлагатай газраа ерөөсөө хөрөнгө оруулалт байхгүй. Нэг л өдөр энэ байгалийн баялаг чинь дуусна. Дуусаад энд байгаа ажилчид нь яваад өгнө. Цаана нь хэн үлдэх вэ энэ газар нутгаа ухуулсан, сэндийчүүлсэн, ийм л орон нутгийн уугуул иргэд л энд чинь үлдэнэ шүү дээ. Тэгэхээр уул уурхайгаа дагуулаад аль болохоор энэ боловсруулах үйлдвэр, энэ газар тариалан, аялал

жуулчлалын тэр бүс нутагт нь дагуулж хөгжүүлж байхгүй бол хэдэн жилийн дараа энэ онгойсон хар нүхнүүд л үлдэх ийм л ирээдүй Өмнөговьчуудыг хүлээж байна.

Жилээс жилд ордог хур тунадасны хэмжээ нь багасаад, гардаг ургамлын тоо нь багасаад, нутагтаа өвөлждөг, хаварждаг, зунждаг ийм малчин байхгүй болоод, малчдын залуу халаа залгамж үе нь байхгүй болоод ингээд нэг ийм байдалтай болоод байгаа учраас цаашидаа энэ хөтөлбөрийнхөө хэрэгжүүлэх газрыг сонгохдоо бас тооцоо судалгаагаа бодитой хийдэг баймаар байх юм. Энэ зориулах ажлуудаа сонгохдоо энэ сургалт семинар янз бүрийн зүйлүүд, судалгааны ажилд биш яг бодитой ажлуудад энэ гаднын зээл тусламж, энэ чинь мэдээж хүүтэй зээл тусламж энэ дотор чинь явж л байгаа. Монголын ард түмэн бидний татварын мөнгөөр л эргээд л төлөх ийм л гаднын зээл л явж байгаа шүү дээ. Тийм учраас энийгээ хэрэгжүүлэх газраа зөв сонгож, хийх ажлаа зөв сонгож цаашидаа явж байх хэрэгтэй.

Цаашидаа тэгээд аливаа зээл тусламж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх аймгаа, сумаа сонгохдоо бас Өмнөговь аймгийг битгий хаяж байгаач гэж л та бүхнээс гуйя.

Б.Энх-Амгалан: Би нэг санал хэлье. Монгол Улс АХБ хоорондын аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл хөтөлбөрийг бол дэмжиж байгаа юм. Энэ бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан ногоон хувьсгалын хүрээнд хийгдэж байгаа маш олон ажлуудын нэг санхүүжүүлэхэд энэ зээл маш чухал үүрэгтэй. Энэ 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэнэ гэдэг бол бид нар эрүүл эко, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр улс орноо хангах хамгийн том эхлэл нь гэж ойлгож байгаа юм.

Тэгээд бүсчилсэн хөгжлийг хангах, бэлчээрийн доройтлыг бууруулах, энэ агро

бизнес эрхлэгчдээ дэмжих, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, ХАА-н паркуудыг дэмжих, тэдний дэд бүтцийг дэмжих асуудал бол маш чухал. Ийм урт хугацаатай, бага хүүтэй, хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөл нь ингээд их боломжийн 40 жилийн хугацаатай. Дээр нь 78 сая долларын буцалтгүй тусламжтай энэ зээл бол энэ бид нарт олдож байгаа нь бол бас үнэхээр бас нэг амны хишиг гэж хэлмээр байгаа юм. Энэ чинь бол маш чухал зүйл.

Гэхдээ гишүүдийн хэлээд байгаа зүйлийг та бүхэн маань онцгой анхаар. Гэрээ хэлцэл байгуулахдаа ялангуяа энэ зээлийн үр ашиг гэдэг юмыг Монгол улсаа наагаач гэж дахин, дахин хэлээд байгаа энийг л онцгой анхаараарай. Яагаад гэхээр бид нар энэ орж ирж байгаа олон улсын зээл тусламжийг харж байхад энэ махны үйлдвэр байгуулах логистикийн төсөл гээд Хөдөө аж ахуйн яам оруулж ирсэн төсөл байгаа. Тэгээд энийг ярьж байхад бол малчин эмэгтэйчүүдийг сургах тухай асуудал ярьж байсан юм. Тэгээд би бас асууж байсан тэр үед нь. Та нар яаж байгаа юм бэ, махыг нь яаж авахыг нь зааж өгч байгаа юм уу эсвэл портер дээр яаж ачиж зөөж ирэхийг нь зааж өгөх гэж байгаа юм уу, юу яриад байгаа юм бэ гэж.

2 дахь нь ингээд ус ургамалтай, гол горхитой, нуур цөөрөмтэй, ой модтой ийм хангайн бүсэд, ийм хангайн бүсэд хашаа хороо барьж өгөх тухай асуудал, худаг усыг нь сэргээж өгөх тухай асуудал ярьж байсан юм. Бас сая Наранбаатар гишүүний хэлж байсан энэ цөлжиж байгаа аймгуудад бол тийм төсөл явахгүйгээр явж байсан юм. Тэгэхээр төслийг үр дүнтэй, Монгол Улсад ашигтай ийм хийх талаас нь л энэ ажлын хэсгийнхэн онцгой анхаарч гэрээн дээрээ суугаарай.

Ялангуяа энэ дээр чинь харагдаж байгаа нэг хэд хэдэн юм байна. 180 орон нутгийн иргэдэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтан сургах гээд. Орон нутгийн иргэдэд малын эрүүл мэнд заана

гэж юу байдаг юм бэ. Наадах чинь энэ мал эмнэлгүүд нь энийгээ хийх ёстой биз дээ мэргэжлийн байгууллагууд нь. Яг ингээд биччихсэн байна шүү, та нар хараарай. Уур амьсгалд тэсвэртэй ХАА-н бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөөг нь боловсруулж өгнө. Тэгээд энэ гаднын зээл тусламжийн хамгийн айхтар юм бол нэг ийм хэдэн юмаар л явж байгаа юм. Зөвлөх үйлчилгээ, сургалт, томилолт, турилага судлах гээд гадаад руу баахан явна. Тэгээд төлөвлөгөөг нь боловсруулж өгнө, зураг төслийг нь хийж өгнө, дадал бий болгоно. Бэлчээрийн доройтлын дадал бий болгоно гэж ямар юм байдаг юм бэ? Чадавхжуулна гээд, ингээд нэг тийм ийм үгийн цаана нөгөө мөнгө нь буцдаг юм явдаг. Энийг л та нар энэ дээр онцгой анхаараарай.

Тэгээд энийгээ дагаад нөгөө техникийн тусламж үйлчилгээ гээд нөгөө техник тоног, төхөөрөмжөө шахчихдаг өндөр үнэтэйгээр. Ийм юмнуудыг л энэ зээл дээр, энэ хөтөлбөр дээр битгий гаргаарай. Ялангуяа энийг зээлийн үр дүн Монгол Улсад маш үр дүнтэй хүрэх талаас нь онцгой анхаараарай гэж ингэж хүсэж байна. Тэгээд зээлийн хэлэлцээрт ороод байхдаа энэ гишүүдийн хэлсэн саналуудыг нэлээн сайн тусгаарай гэж та бүхэнд хэлье.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураана Эрдэнэбат гишүүнээ санал хураана. Та тэнд сууж байгаагүй билүү. Монгол Улс Азийн хөгжлийн банк хоорондын аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. Санал санал хураалтад 10 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулъя.

Байнгын хорооны хурал, өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүд, мөн ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*

